

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
3 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2026 оны 3 дугаар сарын 27-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 – 41

- 1. Монгол Улсын Ерөнхий сайдыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай асуудал* 4 – 41
-

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
3 дугаар сарын 27-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Н.Учрал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 68 гишүүн хүрэлцэн ирж, 54.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 20 цаг 28 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, О.Амгаланбаатар, Х.Баасанжаргал, Д.Батбаяр, П.Батчимэг, Ж.Баясгалан, Б.Бейсен, П.Мөнхтулга, Э.Одбаяр, Г.Уянгахишиг, С.Эрдэнэболд;

Чөлөөтэй: П.Ганзориг, Ц.Даваасүрэн, Ч.Лодойсамбуу, М.Нарантуяа-Нара, Б.Тулга;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Ч.Номин, Б.Пүрэвдорж, О.Саранчулуун, Б.Чойжилсүрэн;

Тасалсан: Ц.Баатархүү, Ж.Батсуурь, Х.Баттулга, Ж.Баярмаа, Х.Болормаа, Д.Бум-Очир, Ш.Бямбасүрэн, А.Ганбаатар, Г.Ганбаатар, С.Ганбаатар, Д.Ганбат, Л.Гантөмөр, Б.Жаргалан, Д.Жаргалсайхан, Ц.Мөнхбат, Л.Мөнхбаясгалан, Ц.Мөнхтуяа, С.Одонтуяа, Г.Очирбат, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пунсалмаа, Р.Сэддорж, Ц.Туваан, Б.Түвшин, Х.Тэмүүжин, Г.Хосбаяр, Да.Цогтбаатар, О.Цогтгэрэл, С.Цэнгүүн, Ө.Шижир, Д.Энхтуяа, Р.Эрдэнэбүрэн;

Хоцорсон: Т.Аубакир–20 минут, Т.Доржханд–02 минут, Б.Мөнхсоёл–35 минут, Б.Найдалаа–35 минут, П.Наранбаяр–25 минут.

Нэг.Монгол Улсын Ерөнхий сайдыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Болормаа, референт О.Мөнгөнчавхдас, А.Амармэнд, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатарын өөрийнх нь хүсэлтийг үндэслэн үүрэгт ажлаас чөлөөлөх асуудлыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлт болон Монгол Улсын Ерөнхий сайдын чөлөөлөгдөх хүсэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Ж.Чинбүрэн, Д.Рэгдэл, Р.Батболд, С.Замира, Н.Батсүмбэрэл, С.Бямбацогт, У.Отгонбаяр, Т.Доржханд нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын дарга Н.Учрал үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 21 цаг 35 минутаас хуралдааныг даргалав.

Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар үг хэлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатарыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудлаар ил санал хураалт явуулав.

Ж.Бат-Эрдэнэ: Гомбожавын Занданшатарын гаргасан Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 19
Бүгд: 73
74.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Гомбожавын Занданшатарыг Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ “Гомбожавын Занданшатарыг Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /21.53/

Уг асуудлыг 21 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 1 цаг 27 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 73 гишүүн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 21 цаг 55 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 3 дугаар сарын 27-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим
20 цаг 28 минут

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Учрал: Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар дараах нэг асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Ерөнхий сайдыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай асуудал.
Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсын Ерөнхий сайдыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай асуудал

Монгол Улсын Ерөнхий сайдыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Ерөнхий сайд өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөх хүсэлтээ гаргасантай холбогдуулж энэ асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдсан.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

Ц.Сандаг-Очир гишүүнийг индэрт урья.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хуралд ирүүлсэн Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарын Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 100 дугаар зүйлийн 100.1 дэх хэсэгт заасны дагуу Төрийн

байгуулалтын байнгын хороо 2026 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар Ерөнхий сайдын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан бөгөөд тэрээр дэлхий нийтийн өмнө нефтийн бүтээгдэхүүний хомсдол, үнийн өсөлтөөс шалтгаалсан эдийн засгийн хямралт байдалтай давхцуулсан улс төрийн энэхүү гацаа түгжээнд зарцуулах нэг өдөр байтугай нэг минут ч манай улсад байхгүй.

Энэхүү улс төржилтийн гацаанаас гаргах нь миний үүрэг хэмээн ухамсарлан эх орон ард түмнийхээ эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайдын албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаж байна.

Хүсэлтийг хүлээн авч Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү хэмээн өөрийн хүсэлтдээ дурджээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томилсноор эхэлж, шинэ Ерөнхий сайдыг томилсноор дуусгавар болно.” гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдыг шинээр томилох хүртэл Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгчээр Гомбожавын Занданшатарыг томилох нь зүйтэй гэж үзсэн болно.

Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарын өөрийнх нь хүсэлтийг үндэслэн үүрэгт ажлаас чөлөөлөхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарын өөрийнх нь хүсэлтийг үндэслэн үүрэгт ажлаас чөлөөлөх асуудлыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарын чөлөөлөгдөх хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Учрал: Монгол Улсын Ерөнхий сайдаас чөлөөлөгдөх шалтгаан үндэслэлийн талаар асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. /алх цохив/

С.Бямбацогт гишүүнээр тасаллаа. /алх цохив/

Сархадын Зулпхар гишүүн үг хэлнэ. /алх цохив/

С.Зулпхар: Асуулт асууж болох билүү дарга аа?

Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатаргаас асуух асуулт байна.

Сая бид Төрийн байгуулалтын байнгын хороонд таны хүсэлтийг танилцаж шийдвэр гаргалаа. Таны хүсэлтийн гол агуулга гадаад талдаа бид хямралтай нөхцөл байдалтай байна.

Тэр нь дайн бүхий байдлаас үүдсэн томоохон эрчим хүчний, нефтийн хямрал бий болсон. Үүнийг дагаад ер нь олон улсад эдийн засгийн хямрал маш тодорхой даамжирч байгаа. Энэ байдал Монгол Улсад ч гэсэн нөлөөгөө үзүүлнэ.

Яг ийм хямралтай нөхцөлд бид дотооддоо улс төрийн хямралтай байж болохгүй гэдэг үүднээс би энэ шийдвэрийг гаргалаа гэдэг Та тийм тайлбар хийж байна. Энэ бол нэг талдаа улс төрийн чухал соёл байх. Үүнийг ойлгож байна. Та төрийн хүний хувьд, туршлагатай хүний хувьд сайтар бодож байж гаргасан шийдвэр гэдэгт эргэлзэхгүй байна.

Түүнээс гадна бид өнгөрсөн хугацаанд тодорхой тоонуудыг таны жишээ нь танилцуулсан байдлаар өнгөрсөн хугацаанд ойлгосон.

Эдийн засгийн өсөлт 2025 онд 6.5 хувьтай байсан. Бид түүхэндээ байгаагүй улсын төсвийн алдагдлыг багасгасан шийдвэр гаргасан. 2.3 их наядын.

Валютын нөөц 7 тэрбумд хүрсэн. Хөдөө аж ахуйн салбар 30 хувиар өссөн. 30 гаруй хувиар сүүлийн жилүүдэд.

Тэр битгий хэл төрийн албан хаагчтай холбоотой, байнга тоотой нь холбоотой шүүмжлэл явдаг. Үүнийг Та бүхэн 2226 мянгаас 214 мянга болгож бууруулсан гэсэн. Цомхон, чадварлаг төр болгох чиглэлээр. Гарсан үр дүнгүүдийн тухай ярьж байсан.

Цаашлаад Оюу Толгой төслийн хүрээнд Оюу Толгой төслөөс Монгол Улсын үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр Улсын Их Хурлын 120 дугаар тогтоол гарсан. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр Та бүхэн хэлэлцээрийн ширээний ард суусан. Тодорхой үр дүнгүүд гарч байсан гэсэн зүйлүүдийг хэлж байсан.

Тэгэхээр гурван асуулт байна. Ер нь жишээ нь Та бүхэн энэ ажил хийх явцад таны кабинетад ямар сорилтууд байсан бэ? Нийгэм, эдийн засгийн. Тэр нийгэм, эдийн засгийн сорилтыг давах чиглэлээр Та бүхэн бүхэлдээ ямар улс төрийн манлайлал үзүүлсэн бэ гэдгийг олон нийтэд ярих хэрэгтэй байна. Үүнийгээ Та бидэнд танилцуулаач гэж байгаа юм.

Хоёр дахь зүйл. Мэдээж хэрэг эдийн засгийн хямрал Монгол Улс руу орж ирэх юм бол томоохон сорилт даах байх.

Тэгэхээр таны хувьд дараагийн Ерөнхий сайдад энэ үүсэж буй нөхцөл байдлаас гарахын тулд ямар улс төрийн, эдийн засгийн, нийгмийн шийдвэрүүд гаргах ёстой вэ гэсэн бэлтгэлийг хангасан уу? Энэ дээр Та бүхэн ажиллаж байсан байх гэсэн ийм асуулт байна.

Гурав дахь зүйл бол “чоно борооноор” гэдэг. Та өнөөдөр тодорхой мэдээлэл өгсөн. Рио Тинто компани манайд бичиг ирүүлсэн. Засгийн газарт бичиг ирүүлсэн. Хэлэлцээрийн ширээний ард овоо сууж байснаа одоо бол ер нь зарим юмнаас ер нь ухарсан байдалтай, буцсан байдалтай, эсвэл биднийг шантаажилсан байдалтай, барьцаалсан байдалтай ийм зүйл бичсэн байна гэж.

Тэгэхээр энэ талаар таны бодол юу байна аа? Энэ тогтоол бол би хэрэгжих ёстой шүү дээ. Засгийн газар хэрэгжүүлэх үүрэгтэй. Хэрэгжилтийг нь хангуулах үүрэгтэй. Цаашлаад Оюу Толгой компани Монголын өөрийнх нь компани учраас энэ хэрэгжилтийг хангах ёстой учраас энэ дээр Та бүхэн ямар бэлтгэл хангаж байна гэсэн асуулт байна.

Төгсгөлд нь мэдээж хэрэг би Гомбожавын Занданшатар Ерөнхий сайдтай хамтарч ажиллаж байсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга байх үед миний дарга байсан учраас бид хамтдаа төрийн ажлын тодорхой ажлуудыг хийж байсан.

Өөрийнх нь мэдлэг, туршлагыг мэдэх үүднээс би Таны хийсэн зүйлийг бид хүлээн авч хүндэтгэж хандаж байгаа шүү гэдгийг хэлье.

Таны улс төрийн цаашдын замнал дардан байх болтугай. Таны ажил, амьдралд сайн сайхныг хүсье. Баярлалаа.

Н.Учрал: Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: С.Зулпхар гишүүний асуултад хариулъя.

Гурван асуулт асуулаа. Ямар сорилтууд байсан бэ гэж.

Өнгөрсөн жил улс төр, эдийн засгийн сорилтууд дүүрэн жил болж түүхэнд үлдсэн. Гадаад орчин дайнтай, хүйтэн. Дотоод орчиндоо бужигнаантай.

Ингээд л байнгын шүүмжлэл, дайралт, олон бэрхшээл, сорилт дундууд бид бүхнийг даван гарч бензин шатахууны хомсдол, төсвийн тасалдал, татварын бууралт, дэлхийн зах зээл дээр нүүрс, манай гол нэрийн бүтээгдэхүүн, экспортын бүтээгдэхүүнүүдийн үнэ ханш хоёр дахин унасан гэх мэтчилэн олон сорилт,

бэрхшээлүүдийг даван туулж, ард иргэдийн амьдралд дарамт учруулаад байгаа хэрэглээний үнийн өсөлт, инфляц 8.3 хувьтай 5 сард, 6 сард 9 хувьтай.

Энэ чигээрээ үргэлжилбэл хоёр оронтой тоонд шилжих тийм эрсдэлтэй үед бид авч одоогийн байдлаар инфляц 6.5 хувь болж буураад байна.

Энэ бол Засгийн газар эдийн засгийн зөв бодлого явуулж, төсөвт тодотгол цаг алдалгүй шуурхай хийж, төсвийн үрэлгэн зардлыг бууруулж, экспорт нэмэгдүүлсний үр дүн.

Төсвийн тэнцэл 432.0 сая долларын алдагдалтай байсан. Одоо 2025 оны эцэст 1 тэрбум долларын ашигтай болж, үүний үр дүнд энэ бол төсвийн хэт тэлэлтийг бууруулж, мөчлөг дагасан бодлого хэрэгжүүлж, экспортыг дэмжсэн нь Засгийн газрын бодлогын бодит үр дүн бөгөөд үүний үр дүнд валютын нөөц 7 тэрбум доллар түүхэндээ анх удаа хүрсэн.

Уул уурхайн салбарт нүүрс бодит хэмжээгээр 90 сая тоннд хүрч, экспорт нэмэгдлээ.

Одоо эхний 3 сарын байдлаар гэхэд өнгөрсөн оны мөн үеийнхээс 40 хувиар өндөр нүүрсний экспорт хийж байна.

Хэдийгээр үнэ нь бараг хоёр дахин буурсан ч гэсэн нийт экспорт мөнгөн дүнгээр үүний үр дүнд 15.8 тэрбум долларт хүрч бодитой хадгалагдаж чадсан.

Тэр дотроо уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлж, самнасан ноолуур 4.7 дахин, махны экспорт 25.7 хувиар нэмэгдсэн нь экспортын бүтэц өөрчлөгдөж, эдийн засгаа солонгоруулж эхэлсний бодит үр дүн болсон.

Ингээд энэ олон сорилт бэрхшээлүүдийг тоочих суух цаг байхгүй. Яагаад гэхээр гадаа хүйтэн байхад дотроо дулаахан байх ёстой би байнга хэлдэг. Гэтэл өнөөдөр дэлхийн 90 гаруй улсад шатахууны хомсдолоос, үнийн өсөлтөөс шалтгаалсан эдийн засгийн хямрал нүүрлэж, зарим улсууд онц байдал тогтоогоод, цаг минуттай уралдан яаралтай арга хэмжээ авч хэрэгжүүлж байхад Улсын Их Хуралд өргөн барьсан шатахууны импортын татварыг тэглэх хууль хүртэл хэрэгжихгүй байна. Энэ бол өсөж байгаад шатахууны үнээ тогтоон барих, улмаар энэ чинь инфляцад шууд нөлөөлдөг суурь үнэ учраас хязгаарлах.

Ингээд муу төсөөллөөр 190 долларт шатахууны үнэ хүрэх. Одоогийн өөдрөг төсөөллөөр 110 доллартой барих энэ гурван сценари төсөөллөөр бид бүх тооцоо судалгааг нь хийгээд гурван шат... /минут дуусав/

Н.Учрал: Ерөнхий сайдын микрофоныг нэмье. Нээж өгье.

Г.Занданшатар: Одоо сорилтыг яаж давах вэ гэхээр давах цогц төлөвлөгөө боловсруулагдсан. Эдийн засгийн тусгай арга хэмжээнүүдийн

төлөвлөгөөг Тэргүүн Шадар сайд Жадамбын Энхбаяраар ахлуулсан ажлын хэсэг Засгийн газрын хуралдаанаар хоёр удаа хэлэлцүүлээд өнөөдөр Улсын Их Хуралд өргөн барихаар төлөвлөж байсан. Одоо ингээд шинэ Засгийн газар бүрдээд энэ бодлого, арга хэмжээг ч тууштай хэрэгжүүлэх шаардлагатай байгаа.

Үндсэн хуулийн 6.2 дахь заалтыг хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Рио Тинто компанид өнгөрсөн оны эцэст захидал явуулаад 1 дүгээр сарын 15-нд ирсэн захидлаар бидний тавьсан 5 асуултуудаар тодорхой яриа хэлэлцээ өрнүүлэхээр хүлээн зөвшөөрөөд 4 удаагийн яриа хэлэлцээ ажлын хэсгүүд амжилттай явуулж байна.

Энэ хүрээн дотроо 5 тавьсан асуудал Монголын талын үр өгөөжийг 60 хувьд болгох. Оюу Толгойн төсөлд Монголын ард түмний хүртэх үр ашгийг 60 хувьд хүргэх. Хэдийгээр тогтоол 53 хувь гэж байгаа боловч бид бусад уул уурхайн дотоодын компаниудаасаа... /минут дуусав/

Н.Учрал: С.Зулпхар гишүүн тодруулъя.

С.Зулпхар: Ерөнхий сайд сая цаг нь хүрээгүй учраас бүрэн хариулж чадсангүй.

Тэр Рио Тинтогийн манай талд Засгийн газарт өгсөн хариулттай холбогдуулаад таны хариултыг бүрэн авъя. Баярлалаа.

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Ингээд нэгдүгээрт Монголын талын үр өгөөжийг 60 хувьд хүргэх, дотоодын компаниудтай 60 хувиар тохиролцоо хийгээд бид гэрээ байгуулаад явж байгаа учраас энэ жишгээ баримталъя гэж шаардлага тавьсан.

Хоёрдугаарт, зээлийн хүүг бууруулах.

Гуравдугаарт, менежментийн төлбөрийг хоёр дахин илүү бууруулах.

Дөрөвдүгээрт, бид ногдол ашгийг 10, 20 жил хүлээгээд байна гэж байгаа.

Бид энэ жилээс хүртэж эхэлье, урьдчилж авъя гэдэг ийм асуудлууд.

Тавдугаарт нь, Онтрэг Монгол Улсад ашигтай хэлбэрээр гэрээ хэлцэл байгуулах ийм 5 шаардлага тавиад тодорхой прогресс ахиц дэвшилтэйгээр яриа хэлэлцээрүүд өрнөж байсан.

Ингээд уулзалтын үеэр бидний тавьсан асуултууд дээр бүтээлч санал, санаачилгууд өрнөж тодорхой ахиц дэвшлүүд гарч байсан. Энэ ажил үргэлжлэх ёстой.

Одоогийн явагдаж байгаа улс төрийн тодорхой бус байдал яриа хэлэлцээнд ямар нэгэн хэмжээгээр нөлөөлж байгааг бид бодитой харж байна. Үүнээс болоод яриа хэлцэл удааширч байгаа. Айлын төлөө өгч байгаа саналууд өөрчлөгдөж байгаа жишиг нь энэ бодит байдлыг харуулж байна гэж хэлж болно.

Ингээд цаашдаа сорилтуудыг даван туулах... /минут дуусав/

Н.Учрал: Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууна, үг хэлнэ.

Ж.Чинбүрэн: Би асуулт үгээ цуг хэлье.

Нэгд төрийн хар хүн ёс зүйтэй байх. Сандал ширээ төлөө биш улс эх оронд тулгамдаж байгаа асуудлыг, сорилтуудыг харж чадаж байгаа бусдадаа үлгэр жишээ болж чадаж байгаа танаар бахархаж байна.

Эрүүл мэндийн салбарт Ерөнхий сайдаар томилогдонгуутаа ханцуй шамлан улаан бурхны нөхцөл байдалтай очиж танилцаж, гэм зэмгүй олон жаахан хүүхдүүд амьсгалын аппараттай ухаангүй тэр хүнд нөхцөлд долоо хонолгүй цуг очиж байсан.

Сар бүр эрүүл мэндийн салбарын тулгамдаж байгаа асуудлыг газар дээр нь очиж үзэж ажиллаж, тэр байтугай Засгийн газрын нөөц хөрөнгөөс хоёр ч удаа санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байсан бол одоо тантай нэг кабинетад ажиллаж байсан Эрүүл мэндийн сайд хүний хувьд маш их дэмжлэгтэй ийм зүйл байсан.

Түүнээс гадна бид хоёр ч удаа төсөв баталсан. Ялангуяа 2026 оны төсөв батлахтай холбогдуулан бид нээлттэй олон нийтийн саналыг авч, тэр дотроо төсвийн урсгал зардалд ямар нэгэн ачаа бололгүйгээр бид хөрөнгө оруулалтыг 5.5 дахин нэмсэн.

Энд бид гадаадын донор орнууд, нэн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж гээд нийтдээ 1.3 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтыг 5.5 дахин нэмэгдүүлж, олон чухал төслүүдийг гараанаас нь хөдөлгөлөө. Тухайлах юм бол сэргийлж болох нас баралтыг яримаар байна. Жилдээ бид 18 мянган иргэдээ алддаг бол 2028 онд 16 мянга болгохоор том амбицтай зорилго агуулан энэ төслөө төсөл биш гараанаас нь гарсан. Одоо ажил болоод ажиллаж байгаад их талархаж байна.

Эрүүл мэндийн салбарын ажилчдын цалин 75.0 хувь нэмэгдлээ. Бид ердөө төсөв дээр нэмэлт урсгал зардлаас 190.0 тэрбум төгрөгийн дэмжлэг авсан ч гэсэн эрүүл мэндийн салбарын ажилчдын 35, 36 мянган иргэд ажилчдын цалинг 75.0 хувь нэмэгдүүлж, жирийн залуухан эмч ТҮ-4 ангилалд байгаа сая 400 мянган төгрөгийн цалин авч байгаа залуу эмч, сувилагч өнөөдөр оны эцэст 2 сая 440 мянган төгрөг авахаар боллоо.

Энэ бол том дэвшил гэж харж байна.

Таны цэгцрэх хөдөлгөөн. Энэ хөдөлгөөн дотор бид Эрүүл мэндийн даатгалын санг санхүүгийн сахилга баттай болгож, онгорхой уутнуудын урагдлыг нь оёж засаж 520.0 тэрбум төгрөгийн өр ширтэй гарахаас бид хамгаалж сэргийлж чадлаа.

Эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан бид анхан шатын тусламж, үйлчилгээг бодитой нэмэгдүүлж, анхан шатын тусламж үйлчилгээг бодитой болгох энэ том зорилтуудаа биелүүлж чадсан.

Тэр дотроос онцлоод хамгийн чухал зүйлийг хэлмээр байгаа юм. 30-аас 60 насны залуучууд, эрэгтэйчүүд нас баралт нь 4 дахин ихсэж байгаа бол бид энэ дээр онцгой анхаарал тавьж, санхүүгийн аргаар стратегийн худалдан авалт хийхээр нас баралтыг бууруулах том зорилго тавьж чадсан.

Тэгэхээр би танаас асуух гэж байгаа зүйл бол одоо бидэнд тулгамдаад байгаа энэ сорилтууд, энэ эдийн засгийн энэ хүнд нөхцөл байдал эрүүл мэндийн салбарт хэрхэн нөлөөлөх вэ гэдэг дээр Та хоёр, гурван жишээ хэлж өгөөч гэж хүсэж байна.

Н.Учрал: Ж.Чинбүрэн гишүүний асуултад Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Макро эдийн засгийн өсөлтийн бодит үр дүнг айл өрх болгоны үүд хаалгаар оруулах, цэгцрэх 300 хоногийн ажлын төлөвлөгөөг Засгийн газраас боловсруулж батлаад хэрэгжүүлж байгаа.

Энэ 300 хоногийн ажлын төлөвлөгөөнд яам, газар, агентлаг болгонд чиглэл, үүрэг өгөгдөж, энд яг айл өрхөд амьдралд наалдацтай, хүнд наалдацтай, хүний амьдралд наалдацтай бодитой юм л хийх гэсэн шаардлага тавьсан.

Өмнөх Засгийн газрын хуралдаанаар гэхэд бид 104 ажлын төлөвлөгөө нэг бүрчлэн яг айл өрх болгоны үүд хаалгаар орох тэр зөвшөөрлийг хөнгөвчлөх, ард иргэдийн хүнд суртал чирэгдлийг багасгах, өртөг зардал багатай боловч амьдралд өгөөжтэй наалдацтай бүх ажил хийх ийм даалгавар өгч ажиллаж байгаа.

Энэ дотроо татвар чирэгдэл, нийгмийн даатгалын шимтгэл, татварын багц хуулийг Улсын Их Хуралд өргөн барьж 2.7 их наядаар бууруулахаар төлөвлөөд байна.

Ийм цогц 300 хоногийн ажлын төлөвлөгөө батлаад Засгийн газар хэрэгжүүлж байгаа.

Энэ 300 хоногийн ажлын төлөвлөгөөгөө бид хоёр долоо хоног тутамд нэг удаа засгийн газраа хэлэлцэж, үүрэг чиглэлийг нь өгч баталгаажуулж ажиллаж байгаа.

Энэ дээрээ нэмээд олон улсын байгууллагуудын судалгаагаар тодорхойлсон 104 тодорхой ажил байна. Яг ард иргэдийн айл өрхөд орох амьдралд наалдацтай макро биш микро түвшинд наалдах ийм бодитой ажлуудыг төлөвлөөд явж байгаа. Энэ ажлаа тууштай хэрэгжүүлэх хэрэгтэй.

Энэ сорилтууд бол хэдийгээр хүнд бэрхшээлтэй боловч бид зохицуулах арга замууд байгаа. Үүнийг тодорхойлсон, төлөвлөгөөнд тусгагдсан, гадаад харилцааны чиг шугамаар яриа хэлцэл явуулж манайхыг тогтвортой хангаж байгаа Оросын Холбооны Улсын Засгийн газарт талархал илэрхийлэхийн зэрэгцээ бид үнээ тогтворжуулах саналыг тавьсан. Нааштайгаар судалж үзэхээ хариу ирүүлсэн.

Мөн төмөр зам, тээвэр, газын хоолой, зэс, гангийн төслүүд амжилттай хэрэгжээд эхэлсэн.

Энэ бүхэн ард иргэдэд бодитой амьдралд үр дүнгээ өгнө. Ийм ажлууд үргэлжлэх ёстой. Тууштай хэрэгжих ёстой. Энэ ч гэсэн тууштай хэрэгжиж чадна гэдэгт би итгэлтэй байгаа.

Гагцхүү энэ үед ёс суртахууны өндөрлөгт байж, бид энэ ард түмнийхээ өмнө тулгараад байгаа энэ асуудлуудыг шийдэхийн төлөө том эрх ашгаа харж ажиллаж сурах ёстой гээд л үлгэр жишээ болох гэж би ийм алхам хийж байгаа юм.

Хувийн явцуу эрх ашиг, тулга тойрсон хэрүүл биш ард иргэдэд юу хэрэгтэй байна гэдгийг л бид анхаарах ёстой. Ийм төрийн түшээд. Төр засаг бол ард иргэдэд шаардлагатай байгаа тэр тайван сайхан амьдралын төлөө л ажиллах ёстой болохоос биш аль улс төрч хэн нь ямар хожилд хүрэх хамаагүй. Ийм учраас би албан тушаалтай зууралдахгүй. Хувийн эрх ашгаа хойшоо тавиад том эрх ашгаа бодоод, улс орныхоо эрх ашгийг эн тэргүүнд тавиад ажиллаач ээ гэсэн үлгэр дуурайлыг үзүүлж Улсын Их Хурлын гишүүддээ уриалга гаргаж байна гэж Та бүхэн ойлгоорой. Үүнийг.

Энэ бол би зөвхөн албан тушаалаа өгч байгаа хэрэг биш. Өнөөдрийн нийгмийн энэ ёс зүйгүй хандлага, хэрээсээ хэтэрч байгаа худал мэдээлэл. Энэ юманд нийгмээрээ бид нэг хариуцлагатай байж хаана хаанаа хариуцлагатай байж суръя.

Ингэж улс орны эрх ашгаа бодоод хойшоо алхаж, том эрх ашгаа бодож нэгдэж чадвал бид бүх асуудлыг шийдэж чадна.

Н.Учрал: Ерөнхий сайдад нэмэлт 1 минут.

Г.Занданшатар: Энэ бол бидний энэ сорилтыг даван туулах арга зам.

Улс орныхоо, ард иргэдийнхээ эрх ашгийн төлөө нэгдэж чаддаг, том эрх ашгийн төлөө нэг байж чаддаг, хувийн жижиг шунал хүслээ хаяж чаддаг, айдас шуналаа даваад том эрх ашгаа бодож чадахыг л би үлгэрлээ гэж бодож ийм шийдвэр гаргаж байгаа юм.

Надад хүсэл, айдас, шунал алга. Ийм учраас би албан тушаалтай зууралдахгүй. Улс орныхоо эрх ашгийг бодно. Хулгайтай эвлэрэхгүй, худалдаа эвлэрэхгүй, ийм л зарчмаа баримталж ажиллаач ээ гэж Та бүхэндээ уриалж би ийм шийдвэрийг гаргаад өчигдөр 10.00 цагт энэ шийдвэрээ би пост гаргаж Та бүхэнд, нийт иргэддээ мэдээлсэн.

Н.Учрал: Ж.Чинбүрэн гишүүн нэмэлт 1 минут.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр би Ардчилсан намынхаа энэ парламентын гишүүддээ зориуд хэлмээр санагдаж байна.

4 сарын өмнө намын дарга Их Хурлын дарга байж болно гэж хэлчхээд одоо дахиад 4 сарын дараа болохгүй гээд хэлж байгаа нь өөрөө хэр ёс зүйтэй байгаа вэ гэдгийг асуумаар санагдаж байгаа юм.

Ингээд Г.Занданшатар Ерөнхий сайд Танд надад итгэл үзүүлж нэг кабинет оруулсанд гүн талархал, энд нэр төрийн хэрэг байлаа. Ингээд эрүүл мэндийн сайдын хувьд биш, эмч хүний хувьд салбарынхаа нэрийн өмнөөс эрүүл мэндийн салбарт ээлтэй Ерөнхий сайд байсан танд бүр талархсанаа илэрхийлье.

Н.Учрал: Д.Рэгдэл гишүүн асуулт асууна.

Д.Рэгдэл: Баярлалаа. Тэгээд үнэхээр одоо бид нар нэгдмэл байж чадах их чухал юм. Сая Ерөнхий сайд хэллээ. Нэгдээд ирэхээрээ өнөөдөр бараг шөнийн цагаар ирцээ бүрдүүлээд л Их Хурлаа явуулж чадаж байна.

Тэгэхээр зэрэг өнөөдөр манай Их Хурлын олонх цөөнхийг бүрдүүлж байгаа, сөрөг хүчнийг бүрдүүлж байгаа хоёр бүлгийн зарим улс төрчдийн хэт улс төрийн хийрхэлээс болоод Засгийн газар унагах алхамд орохоос өөр замгүй болсонд их харамсаж байгаа юм.

Тэгэхээр миний бие их олон жил насалж байгаа болохоор Юмжаагийн Цэдэнбал гуайгаас эхлээд Гомбожавын Занданшатар хүртэлх Ерөнхий сайд нарыг нэг хол ойроос харж явсан хүн юм.

Энэ ардчиллын жилүүдэд Засгийн газар хэдий хурдан солигдож байсан боловчиг бас цөөн тооны сайн Ерөнхий сайдууд байсан юм. Юуны өмнө

Пунцагийн Жасрай гуайг би нэрлэмээр байна. Ямар хүнд үед засаг аваад яаж дээш нь өндийлгөж байлаа.

Би бол Г.Занданшатар Ерөнхий сайдыг бас тэр зиндааны Ерөнхий сайд гарч ирж байгаа юм байна даа гэж харж явдаг байсан. Харамсалтай нь өнөөдөр өөрийнхөө хүсэлтээр энэ ажлаа өгье гэж Их Хуралд оруулж ирж байгаа юм байна.

Энэ бол харахад хүсэлт гэж бичигдсэн боловчиг үнүүнийг хэлэхэд эх оронч санаачилга юм. Ингэхгүй бол манай улс төрд нүүрлэсэн энэ хийрхэл маань системээ бараг зогсоочих аюултай ийм байдалд хүрсэн учраас хамгийн түрүүнд санаачилга гаргасан танд талархаж байна. Талархаж байна. Тэгээд нөгөө хоёр асуулт байх юм.

9 сар гаруй ажиллалаа. Энэ хооронд манай эрдэс баялгийн салбарын асуудлаар нэлээн олон ажил хийсэн. Тэр дундаа Рио Тинтотой хэлэлцээрийг амжилттай эхлүүлээд хоёр дахь уулзалт дээрээ нэлээн чанга шаардлага тавьсан. Та нарын оруулж ирж байгаа энэ санал надад таалагдахгүй байна гэж хэлсэн.

Дараа нь мөн саяхан усны төлбөрөө төлөхгүй бол ус өгөхгүй гээд хэлчихлээ.

Тэгээд Г.Занданшатар сайдын огцрох гэж байгаа цаг үе энэ хоёр мэдэгдлийн цаг үе энэ тэр ингээд цаг хугацааны хувьд таараад байгаа юм. Гадуур ингээд Рио Тинтотой үзэлцсэн хүн унадаг юм даа л гэж байна. Би тэгж бодохгүй байна. Тэгж ер нь бодохыг ч хүсэхгүй байна.

Гэхдээ Рио Тинтотой хийж байгаа энэ хэлэлцээр маань яг одоо ямар шатдаа явж байгаа юм? Энэ хамгийн дээд зорилго маань хаана хүрэх юм? Тэр хүүгийн хэмжээ нь хэд болоод бидний хүсэл эрмэлзлийг хангах юм?

Монголын ард түмэнд өгөх ашиг нь хэдэн хувь болохтой зэрэг энэ маань Монголын ард түмний Үндсэн хуульд заасан эрхийг хангах юм гэдэг дээр Та нэг тодорхой хариулт өгөөч гэсэн нэг ийм асуулт байна.

Хоёрдугаарт, сая Ж.Чинбүрэн сайд ярилаа. Энэ цалингийн асуудлаар.

Тэгэхээр сүүлийн жилүүдэд төрийн албан хаагчдын цалингийн хувьд хамгийн том ажил хийсэн Ерөнхий сайд гэж би таныг бодож байгаа юм. 2026 оны төсөвт боловсролын салбарын цалингийн нэмэгдэлд 519.0 тэрбум төгрөг тавьсан санагдаад байгаа юм. Зөвхөн цалингийн нэмэгдэлд.

Гэтэл өнөөдөр боловсролын салбараар ямар яриа яваад байна вэ гэхээр энэ багш нарын цалин нэмэгдээгүй. Заримынх нь хасагдсан байна гэж байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, манай үйлдвэрчний байгууллагын хамгийн том дарга Монголын. Цуглаагаараа хэлж байна. Энэ боловсролын салбарын ажилчдын цалин нэмэгдсэн нэмэгдээгүй нь мэдэгдэхгүй байна гэж байгаа юм. Үгүй энэ чинь нэг салбарт 520-иод тэрбум төгрөг цалинд нь нэмээд өгөхөөр цалин нэмэгдэхгүй байна гэж ер нь энэ юу болж байгаа юм. Энэ яахаараа ингэдэг юм бол?

Энэ салбар ингэтлээ дампуурч доройтсон юм уу? Эсвэл Улсын Их Хурлын гишүүн бид 519.0 тэрбум төгрөг худлаа нэмээд хий нэмэгдсэн юм уу? Энэ тал дээр Та нэг тайлбар өгөөч.

Тэгэхдээ ер нь энэ төрийн албан хаагчдын цалин маань алаг цоогтой нэмэгдээд нэлээн зөрүүтэй болчихлоо.

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: 2026 оныг боловсролын жил болгож зарлаж, энэ хүрээнд үндсэн хоёр ажил хийсэн.

Багш, ажилчдын суурь цалинг 50 хувиар нэмсэн. Үүнтэй холбогдуулаад цалингийн бүтцийг шинэчилж, цаашдаа суурь буюу үндсэн цалинг тогтвортой нэмэх боломжийг бүрдүүлж, үндсэн цалин, нэмэгдэл цалингийн харьцаа 50, 50 байсныг 70, 30 болгож өөрчлөлт хийсэн.

Энэ бол янз бүрээр ойлгогдож байгаа юм билээ. Ер нь боловсролын салбарын реформ нэг номерт. Багш хамгийн эрхэм нэр хүндтэй ажил байх ёстой. Эрхэм нэр хүндтэй ажил байж, өндөр цалинтай байж, суурь цалин нь өндөр байж тэр салбарт ажилладаг сайн багш нар бий болно.

Тийм учраас ажилласнаараа олгодгоосоо гадна анх орж байгаа залуу багш нар сая 484 мянган төгрөгийн цалинтай байсныг 2 сая 284 мянган төгрөгийн цалинтай болж өсгөх, сайн багш нартай болох, дутагдалтай багш нарын салбарыг нөхөх энэ гол бодлого чиглэлийг хэрэгжүүлсэн. Тэгээд энэ дотроо суурь цалинг нэмсэнтэй холбоотой янз бүрийн маргаан байдаг.

Би 11 аймагт явж багштай уулзаж байхад ер нь санал, гомдол яг тулаад ярихаараа гайгүй байдаг юм.

Ингээд хоёр сайд дээр чөлөөлөгдөх учраас дэлгэрэнгүй ярих байх. Ер нь 2026 оны төсөвт боловсролын салбарын төсөв 5.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оныхоосоо 1.1 их наяд төгрөгөөр нэмэгдсэн. “Боловсролын жил”-ийн гол зорилго.

Төсвөөр шинэ 39 сургууль барина. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр 33 сургууль, цэцэрлэг барих санхүүжилтийг шийдсэн. Ингээд нийт 175 шилжиж байгаа барилга баригдаж дуусна.

Ингээд сургуулийн өмнөх боловсрол, бага боловсролын хөтөлбөрийг шинэчилсэн. Энэ салбар мэдээж нэлээн хэл амтай, зөрчил тэмцэлдээнтэй байсан нь үнэн боловч бодитой шинэчлэлүүд хийгдсэн нь үнэн юм шүү.

Үүнийг боловсролын салбарын реформын хамгийн суурь нь багшийн ажил нэр хүндтэй байхаас, багшийн үнэлэмж өндөр байхаас эхлэх учраас энэ цалин хөлсний бодлогыг цаашдаа ч гүнзгийрүүлж шинэчлэх хэрэгтэй. Ингэж байж нэлээн том цогц реформын төлөвлөгөө баталсан байгаа.

Энэ чиглэлээр ажиллана. Цаг бага байгаа учраас товчлоод хэлэхэд ер нь цалингийн асуудал ингээд яригдаад явах байх. Сайдыг нь чөлөөлсөн. Өөрийн хүсэлтээр ч гэсэн чөлөөлсөн. Түүн дээр асуудлуудыг нь ярих байх.

Ус бохирдуулсны төлбөр Рио Тинто компаниудад 5 шаардлага тавиад байгааг дээр дурдсан. Монгол Улсад хүртэх өгөөжийг 60 хувь байлгаач ээ гэж байгаа юм. Улсын Их Хурлын тогтоол 53 хувь гэж байгаа ч гэсэн бид бусад дотоодын компанидаа 60 хувь гэж шаардлага тавьж стратегийн ордууд дээр ийм тохиролцоонд хүрчхээд ялгавартай хандах ёсгүй. Ийм боллоцоо бий гэж үзэж байгаа. Бүх тооцоо анализыг хийж үзсэн.

Хоёр тал дээр энэ дээрээ санал нэгдэж байгаа. Өгөөжтэй байх ёстой дээр.

Үүнийгээ дагаад бид энэ зээлийн хүүг бууруулах, ногдол ашгийг урьдчилж авах... /минут дуусав/

Н.Учрал: Ерөнхий сайдад нэмэлт 1 минут.

Г.Занданшатар: Дивидентийн төлбөрийг хоёр дахин бууруулах зарчмын тохиролцоонд хүрээд байгаа.

Зээлийн хүүг бууруулах зарчмын тохиролцоонд хүрээд гарын үсэг зурчихсан.

Бүр илүү том амжилтад хүрэхээр бид нэлээн том тохиролцоотой 500.0 сая долларын урьдчилгаа авах талаар Gold Stream & Forward хэлцэл гээд тодорхой бүтээлч санаачилгууд гараад яриа хэлцэл амжилттай үргэлжилж байсан. Харамсалтай нь одоогийн энэ улс төрийн тогтворгүй байдлыг үүсгэсэн гэж хэлэхгүй ч гэсэн энэ нөлөөлсөн гэж би хэлж, бодож байгаа.

Ийм учраас яриа хэлэлцээр сааталтай байгаа ч гэсэн энэ Монголын төр байсан цагтаа энэ ажил үр дүнтэй болох ёстой. Энэ тууштай хэрэгжих ёстой.

Ер нь бидний энэ Үндсэн хуулийн 6.2 дугаар улсын зарчмын шаардлага бол нийт уул уурхайн компаниуд дээр тавигдаж, бодитой хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэхээр Баялгийн сангийн хуулийг Улсын Их Хуралд өргөн барихаар зөвлөлдөх санал асуулгыг энэ 4 сарын 10-нд зохион байгуулахаар ажиллаж

байна. Нийт ард иргэдтэйгээ зөвлөлдөж байгаа ийм том санаачилга өрнөж байгаа. Энэ ардчиллын шинэ хэлбэр. Ардчиллыг төгөлдөршүүлж байгаа. Ард түмнийхээ оролцоо, санаачилгыг хангасан... /минут дуусав/

Н.Учрал: Р.Батболд гишүүн асуулт асууна. Д.Рэгдэл гишүүн тодруулах юм байна.

Д.Рэгдэл: Энэ цалингийн асуудал дээр би цагтаа багтаж асууж чадсангүй.

Ер нь энэ салбаруудын цалин харьцангуй тэгш нэмэгдэх ёстой гэж бодоод байгаа юм. Тэгээд дараагийн Засгийн газарт хэрэгтэй гэж бодоод байгаа юм л даа би. Энэ цалингийн реформыг ер нь Та цаашид нь яаж үргэлжлүүлж хийх гэж төлөвлөж байсан юм бол? Энэ талаараа нэг товчхон тайлбар өгнө үү?

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Ер нь товчхондоо төрийн албаны цалингийн цогц реформыг хийхээр төлөвлөж, зөвхөн гүйцэтгэлд шилжих. Жишээлбэл, соёлын салбар гэхэд сумын соёлын төвд хөгжмийн багш, бүжгийн багшаасаа гадна үр дүнтэй өөрсдөө орлого олдог, бүх аймаг, орон нутагт эрхийг нь өгөөд тэр хэмжээгээрээ цалингаа нэмэгдүүлдэг, орон тоогоо зохицуулдаг тэр эрхийг нь өгөх тийм төсвийн шинэчлэл хийх.

Ингэснээрээ нийт салбарын бүтээмж дээр тулгуурласан гүйцэтгэл үр дүн дээр тулгуурласан цалингийн шинэчлэлийг хийх ийм чиглэл бодлогыг манай Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хэрэгжүүлээд 2027 оны төсөвт тусгахаар ажиллаж байгаа.

Хамгийн тулгамдсан асуудал бол багш, эмч нартай тулгамдсан үйлдвэрчний эвлэлтэй тохирсон гурван талт хэлэлцээрээр 2026 он гэхэд 30 хувь нэмэгдүүлнэ гэсэн тохиролцоондоо нэг ч хувь хүрээгүй байсан учраас л энэ асуудал үүссэн. Үүнийг эхний ээлждээ хүний хөгжил, багш, эмч, боловсрол, эрүүл мэндийн салбарынхаа цалинг нэмэх чиглэл барьсан. Бусад салбарууд дээр гүйцэтгэл, үр дүнд тулгуурласан... /минут дуусав/

Н.Учрал: Ерөнхий сайдад нэмэлт 1 минут өгье.

Г.Занданшатар: Тэгээд энд цалингийн сүлжээ, албан хаагчдын бүтээмж хоёр шууд холбоотой байгаа. Хувийн компанид. Үүнийг л хойшид их анхаарах хэрэгтэй юм билээ.

Жишээлбэл, 2026 оны төсөвт 226 мянган төрийн албан хаагчид авахаар орон тоо төсөв баталсан. Одоо яг цалин авч байгаа цалин яг ний нуугүй шулуухан хэлэх юм бол бодит цалингийн хүснэгтээрээ 195 мянга 355 хүн цалин авч байгаа.

Бид 30 гаруй мянган орон тоо хэмнэсэн явж байгаа. Албан ёсны статистикаар бид 14 мянган орон тоо нэмэгдсэн явж байгаа.

Энэ мэдээж төрийн албан хаагчдын маань цалин хөлс, урамшууллыг нэмэгдүүлэх энэ суурь болох ёстой. Орон тоо, бүтэц оновчтой байж нэг хүний ажлыг хоёр хүн хийж байвал илүү өндөр, хоёр дахин илүү цалин авдаг байх ийм цогц реформ шинэчлэл хийх боломжууд байна гэдгийг нь харуулж байгаа.

Ийм учраас орон тоо, бүтэц, төсвийн бодлого... /минут дуусав/

Н.Учрал: Р.Батболд гишүүн асуулт асууна.

Р.Батболд: Оройн мэнд хүргэе. Эрхэм гишүүдэд.

Өнөөдөр Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар Ерөнхий сайдын албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан байна.

Тэгээд бид энэ талаар ярилцаад сууж байна. Энэ шийдвэрийг гаргахад мэдээж цөөнхийн бүлгийн гишүүд болон олонхын бүлгийн зарим гишүүд нөлөөлсөн байх л гэж бодож байна.

Тэгээд авч чадсан юм чинь өгч чаддаг байх хэрэгтэй гэдэг ийм үлгэр дуурайлал үзүүлээд ийм шийдвэр гаргаад явж байх шиг байна.

Ер нь харамсалтай байгаа. Яагаад вэ гэдгээр гурван зүйл хэлье.

Нэгдүгээрт нь, Засгийн газар тогтвортой үйл ажиллагаа явуулж байж улсын эдийн засаг болон ард түмний ахуй амьдралд нааштай нөлөө үзүүлэх ёстой.

Тэгэхээр биднийг ер нь гадаад талдаа юу гэж харж байгаа бол? Гаднын хөрөнгө оруулалт бид нар татъя гээд яриад байдаг. Энэ асуудлууд хаашаа шийдэгдэх гэдэг ийм сэтгэл зовнисон асуудал нэгдүгээрт үлдэнэ.

Хоёрдугаарт нь, сүүлийн 2025 оны төгсгөл, 2026 оны хувьд эдийн засгийн үзүүлэлтүүд маань харьцангуй сайн байсан гэж харж байгаа.

Гуравдугаарт нь, дэлхийн эдийн засаг, геополитикийн байдал маш ээдрээтэй болсон. Тодорхойгүй байгаа. Тэгээд дотооддоо эдийн засгийн томоохон цохилт авах гээд бараг хүлээж байгаа энэ үед Засгийн газар солигдох нь.

Хэрвээ кабинетаараа явна гээд сайд нараа солих дээрээ тулбал сайдын суудлын төлөө гээд энэ асуудлууд хэзээ шийдэгдэх вэ гэдэг бас нэг зовнил байна.

Ер нь яах вэ энэ Их Хурлын гишүүд бид өөрсдөө Рио Тинто, Оюу Толгойн даалгавраар хөдөлдөг гэдэг. Хүссэн хүсээгүй бид ийм нэртэй болно. Эхнээсээ хэвлэл мэдээлэл, сайтууд энэ талаар яриад эхэлсэн байна.

Тэгэхээр яах вэ, сая гишүүд маань бүгдээрээ асуучихлаа. Энэ тоон үзүүлэлтүүдийн талаар. Гарсан сайн үр дагавар гэдэг юм уу, нөлөө гэдэг юм уу энэ талаар асуугаад байна.

Тэгэхээр одоо яг аль салбарт вэ гэж асуулгүйгээр зүгээр ер нь хэлээгүй үлдсэн эдийн засгийн тоо үзүүлэлтүүд, тулгамдаж байгаа асуудлуудын талаар Та ер нь, таныг нэг мэдээлэл өгөөч гээд хэлчихье.

Н.Учрал: Ерөнхий сайд хариулья.

Г.Занданшатар: Төрийн бодлого залгамж чанартай байх ёстой.

Тийм учраас энэ зүйлүүдийг яриад байгаа юм шүү гэдгийг би тэмдэглэж хэлэхийг хүсэж байна.

Нэгдүгээр тулгамдсан асуудал бол эрчим хүчний хямрал байна. Эрчим хүчний асуудал байгаа. Энэ бол шатахууны ч асуудал. Бид нефть боловсруулах үйлдвэр үндсэндээ зогсонги байдалд орсоньг маш эрчимжүүлээд 50 хувиас дээш гүйцэтгэлийг гаргасан. 2027 оны 6 сар гэхэд бид ашиглалтад оруулахаар ажиллаж байгаа.

Үүнээсээ илүү манай эрчим хүчний хангамж, хэрэгцээ хоёрын хоорондын зөрөө асар их нэмэгдсэн.

Одоо бид 1 сая 800 мянган мегабайт цахилгаан эрчим хүч хэрэглэж байна. Оргил ачааллын үедээ. Одоо бараг сая 200 мянган мегабайтын техникийн өсөлт, эрэлт хэрэгцээ, шаардлага үүсээд байгаа.

Ирэх онд 350 мянган мегаваттаар нэмэгдүүлэхгүй бол болохгүй. Бодит эрсдэл үүссэн байгаа.

Энэ жилийн энэ цахилгаан эрчим хүчний дутагдал хомсдол ч гэсэн үүний яруу тод жишээ.

Ийм учраас бид эрчим хүчний салбарын үр ашгийг нэмэгдүүлэх, цэгцлэх, либералчлах, үнэ тарифтай холбоотой Засгийн газрын тогтоолыг гурван удаагийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж батлан гаргасан байгаа.

Энэ тууштай хэрэгжиж, яаралтай хэрэгжүүлэхгүй бол, энэ зундаа хэрэгжүүлэхгүй бол сэргээгдэх эрчим хүчний болон манай нүүрсний цахилгаан станц, Сэлэнгийн цахилгаан станц 4 сард ашиглалтад орно. Ингээд энэ бидний хамгийн тулгамдсан асуудал байгаа шүү.

Үүнийг л бид яаралтай шийдвэрлэх хэрэгтэй. Ойрын үед шатахууны зөв менежмент хийх. Ард иргэддээ ч гэсэн бид ний нуугүй шатахууны хэрэглээгээ багасгах, олон улсад бүр алхалтын өдөртэй болж байна, шатахуунаа хэмнээ хийе гэсэн уриалга гаргаж байна. Ийм нийтээрээ нэг төрийн бүх албанд бид шатахууны хэрэглээг бууруулах чиглэл өгсөн байгаа.

Үүнийгээ тууштай хэрэгжүүлээд ойрын хугацаанд дэлхий даяар нүүрлээд байгаа энэ шатахууны үнийн өсөлт, энэ хямралын асуудлыг цэгцлэхэд нийт төрийн байгууллагууд анхаарал тавьж ажиллах шаардлагатай байгаа. Энэ хоёр хамгийн тулгамдсан асуудал байна.

Н.Учрал: С.Замира гишүүн асуулт асууна.

С.Замира: Баярлалаа. Манай Монгол оронд 126 парламентын гишүүнтэй боллоо. Төр, засаг нэлээд тогтвортой ажиллана, улс эх орон маань хөгжинө гэсэн чинь байсхийгээд төр засаг маань солигдоод байдаг боллоо. Энд маш их харамсаж байна.

Одоо Г.Занданшатар Ерөнхий сайд нэлээд ажлуудыг эхлүүлсэн байсан. Хамгийн харамсалтай нь өнөөдөр тэгээд төрийн хүсэлтээр ч юм уу, шахалтаар ч юм уу ингээд ажлаа өгч байгаад нь харамсаж байна.

Тэгээд танаас дөрвөн асуулт асуумаар байна. Та бол Монголын бэлтгэгдсэн боловсон хүчин гэж боддог юм би. Яагаад гэвэл бүх шатны ажил, төрийн ажил, албыг хаасан.

Тийм учраас даян дэлхийд ингээд дайн байлдаан болж, эдийн засаг хямралтай байдалд орж байхад ер нь Монголын төр засаг ойр ойрхон солигдож байх нь зөв гэж бодож байна уу?

Хоёрдугаарт, Оюу Толгойн гэрээ хууль бус, Монгол Улс зээл төлөх ёсгүй, харин ашиг авах ёстой гэдгийг хэлсэн. Усны төлбөр одоог хүртэл төлөгдөөгүй гэдгийг тов тодорхой хэлсэн байгаа.

Дараачийн Засгийн газрын тэргүүнд Та юу гэж захимаар байна? Ямар гэрээ хэлэлцээрийн ширээний ард суух ёстой, ямар шатанд энэ гэрээ хэлэлцээрээ хүрэх ёстой.

Гуравдугаарт, ахмадуудын тэтгэвэр, тэтгэмж гээд нэлээд сараар ахмадууд ингээд ядарсан, суулт хийж байна, асуудал тавьж байна. Төр засагт. Тэр тал дээр ер нь ахмадуудын тэтгэвэр тэтгэмжийг ингэж шийдвэл ийм гарц байна гэдэг Танд эдийн засагч хүний хувьд төлөвлөсөн юм байсан уу?

Дөрөвдүгээрт, гадаадын нэг банк оруулна гээд. Бид хэд яриад байсан. Та ч гэсэн ярьсан. Манай Их Хурлын дарга ч ярьж байсан. Энэ тал дээр энэ банк

оруулж ирэх үйл ажил нь ер нь ямар шатад байсан бэ? Ямар шатад хүрсэн бэ? Ийм дөрвөн асуулт байна.

Н.Учрал: С.Замира гишүүний асуултад Монгол Улсын Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Ер нь усны төлбөр төлж байгаа. Оюу Толгой компани бол.

Ус бохирдуулсны төлбөр жилд 17 сая тонн ус, 87.2 хувийг цэвэршүүлдэг. Тэгээд үлдэж байгаа 13 хувийг нь 17 сая тонн усыг бохирдуулдаг гэсэн үг.

Үүнийг нийтдээ 153 сая куб метр усыг ашиглаад ус бохирдуулаад төлбөрөө төлөөгүй байна гэж акт тавиад Оюу Толгойн акт аудит оруулъя гээд бид ажлын хэсэг аудит оруулж ажиллаж байгаа. Гол ширгэсэн гэх мэтчилэн асуудлууд байгаа.

Тэгэхээр дэлхийн технологи 92 хувь хүртэл хүрсэн, 95 хувь ч хүрч байна. Ус дахин ашиглах recycling бол.

Тэгэхээр ус бохирдуулсны төлбөр төлөхгүй байгаа учраас энэ шинэ технологи нэвтрүүлэхгүй байна гэж би үзэж ийм шаардлага тавьж байгаа. Ингэхгүй говийн ус эмзэг. Говь ямар хуурайшилттай, цөлжилттэй байгаа билээ. Энэ бүхэн ингээд бүхэлдээ яриа хэлэлцээрийн нэг хэсэг, тактикийн асуудал учраас долоо хоногийн өмнөх Засгийн газрын хуралдаанаар бид хаалттай хэлэлцээд хэлэлцээд бүх асуудлаар тодорхой чиглэл гаргасан байгаа.

Бүх бодлого залгамж чанартай үлдсэн байгаа. Энэ үргэлжлээд явах ёстой. Үргэлжилж явна гэдэгт итгэж байна.

Бид 5 асуудлаар зарчмын шаардлага тавиад нааштай яриа хэлэлцээрээр явж байгаа. Энэ Оюу Толгойн яриа хэлэлцээр өөрөө нарийн чимхлүүр, бодит үндэслэл, тооцоолол дээр тулгуурласан, илүү бүтээлч явах юм бол үр дүнд хүрч болно гэдэгт бид итгэлтэй байгаа.

Тийм учраас энэ асуудал цаашаа үргэлжилнэ. Тодорхой стратеги тактикууд гарсан ажиллаж байгаа.

Тэтгэврийн хувьд одоо жишээлбэл бид энэ жил ний нуугүй хэлэхэд Бортээгийн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулж тендер зарлаж 7 компани ирсэн. 1 тэрбум долларын урьдчилгаа төлөх. Үнэ нь биржийн үнээр, “Чайна Энержи”-гээс, Харбины гэрээгээс хоёр дахин үр ашигтай гэрээ байгуулах нөхцөл бүрдээд яриа хэлэлцээд явж байгаа.

Энэ урьдчилсан орлого 1 тэрбум доллар 3.6 их наяд. Мөн саяын Оюу Толгойн урьдчилсан төлбөрүүд. Бид 2 тэрбум доллар олох тооцоо тавиад энэ хүрээндээ цалин, тэтгэвэр, тэтгэмж, нэг удаагийн болон үндэсний баялгийн

сангаас хүртээмж хүргэх ийм халамжийн бодлогын тодорхой шийдлийг эхлээд орлогоо олж байж гаргахаар төлөвлөөд ажиллаж байгаа. Энэ үргэлжилнэ. Одоо 7 компани ирчихсэн. Саналууд нь дээд тал нь 1 тэрбум доллар урьдчилаад төлье гэсэн.

Үндсэндээ Харбины гэрээгээс хэд дахин үр ашигтай тийм яриа хэлцэл явагдаж байгаа.

Гадаадын банкны хувьд гадаадын банк Унгарын ОТП банк болон бусад банкуудтай яриа хэлэлцээ явагдаж байгаа. Бас хууль, эрх зүйн зарим өөрчлөлтүүд орох шаардлагатай гэж үзээд Монголбанк энэ чиглэлээр илүү ажиллаж байгаа. Энэ дээр Улсын Их Хурлын дарга Н.Учрал дарга маань нэлээн санаачилгатай ажиллаад энэ чиглэлээр тодорхой бодлого үргэлжлүүлээд явна гэж итгэж байна.

Н.Учрал: Н.Батсүмбэрэл гишүүн асуулт асууна. С.Замира гишүүн тодруулах юм байна. С.Замира гишүүн.

С.Замира: Ерөнхий сайд би танаас нэгдүгээр асуулт дахиж давтаад асуумаар байна.

Одоо ингээд 4 жил бид 126 гишүүн сонгогдсон байгаа. Парламентад. Одоогийн байдлаар хоёр дахь удаа Ерөнхий сайд нь солигдоод Их Хурлын даргад хүртэл Ардчилсан намынхан суудлаа тавьж өг гэсэн шаардлага хүргээд байна.

Ийм үед ер нь манай төр засаг ийм тогтвортой байдалд орох нь ер нь цаашдаа ингэхгүй гэсэн ямар ч баталгаа байхгүй шүү дээ. Маргаашийн гурав дахь Ерөнхий сайдаар гэхэд дахиад ингэж суухгүй гэсэн.

Тийм учраас ер нь Та үүнийг юу гэж бодож байна? Улс төрч хүний хувьд, эдийн засагч хүний хувьд энд нэг дүгнэлт хийгээд өгөөч ээ гэж танаас хүсэж байна.

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Ер нь аливаа улсын хөгжлийн үндэс нь тогтвортой хөгжлийн бодлого юм билээ.

Гадаад дотоодын бүх шинжээчид, эрдэмтэн судлаачид, хөрөнгө оруулагчид нэг л зүйл хэлдэг. Танайд тогтвортой бодлого алга. Нэг засаг солигдоод маргааш нь тэр яам, сайд чинь байхгүй болсон юм чинь энэ бодлого байхгүй гээд оруулсан хөрөнгө оруулалт, хийж байгаа ажил, бүх юм гацдаг, өөрчлөгддөг энэ тогтворгүй байдал хөгжлийн садаа, гацаа. Энэ тогтворгүй байдлын гацаа нь өөрөө өнөөдөр Улсын Их Хуралд нь нүүрлээд байгаа энэ түгжээ, бойкот, гацаа.

Тэгэхээр энэ дээр бид ёс суртахууны манлайллаар давж хувийн эрх ашгаа хаяад урагшаа хараад том эрх ашгаа боддог ёс суртахууны үлгэр дуурайлал үзүүлж байж шийдэхгүй бол бид хууль эрх зүйн орчныг нь Үндсэн хуулиар шийдсэн хүнээс хамаардаг юм байна гэж би ойлгож байна. Яагаад гэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийгээд, 126 гишүүнтэй болгоод, Засгийн газар, Улсын Их Хурлын эрх мэдлийг нэмэгдүүлээд, хяналт, сонсгол нээлттэй хийдэг болгоод эрх зүйн орчныг бид хангалттай бүрдүүлж өгсөн боловч, бид хангалттай бүрдүүлж өгсөн боловч энэ улс төрчдийн ёс суртахуун, ёс суртахууны өндөрлөг манлайллаас шалтгаалаад ийм гацаанд... /минут дуусав/

Н.Учрал: Ерөнхий сайд нэмэлт 1 минут.

Г.Занданшатар: Ингээд дэлхий дахинаараа хямраад нэг минут, нэг өдөр, нэг цаг алдах эрхгүй ийм өөрчлөлт шинэчлэлтийн ийм эмзэг үе тохиож байхад бид ингээд ард түмнийхээ эрх ашгийг, төрийг төлөөлөх, ард иргэдээ төлөөлөх үүрэг маань гацаанд ороод байгаа бол бид үүнийг хуулиар тайлбарлах боломжгүй ийм ёс суртахууны асуудал болсон байна.

Ийм учраас би энэ дээр ёс суртахууны өндөрлөгт байж, албан тушаалтай зууралдахгүй, үлгэр дуурайлал, манлайлал үзүүлэх үүрэгтэй төрийн өндөр албан хаагч гэж үзэж ийм шийдвэр гаргасан.

Энэ бол хувь хүн болгон улс гэрийг байгуулахад хувь хүн бүрийн ёс зүй, манлайлал, хувийн эрх ашгаа хойш нь тавиад төр ард түмнийхээ төлөө зүтгэнэ гэсэн өргөсөн тангарагтаа үнэнч байхыг л сануулж байгаа санаачилга гэж Д.Рэгдэл гуай онож хэллээ гэж миний бодлыг хэлж болж байна. Энэ зөвхөн хүсэлт биш, санаачилга, уриалга гэж эрхэм гишүүд Та бүхнийг хүлээж авахыг хүсэж байна.

Н.Учрал: Н.Батсүмбэрэл гишүүн асуулт асууя.

Н.Батсүмбэрэл: Энэ өдрийн мэнд хүргэе.

Монгол Улсын 34 дэх Ерөнхий сайд огцорч байна.

1990 оноос хойш 17 Ерөнхий сайд ажиллаж, үүний 4 дэх Ерөнхий сайд нь өөрийн хүсэлтээрээ чөлөөлөгдөж байгаа юм байна.

Манай парламентад байгаа Ардчилсан намын бүлэг маань өнөөдөр орж ирээгүй байна. Өөрсдөө санаачилга эхлүүлсэн. Харамсалтай нь энд орж ирж олон түмнийхээ асуудлыг яриагүй явдалд их харамсалтай байна.

Ерөнхий сайдаас гурван асуулт байна.

Нэгдүгээрт, Европт болж байгаа Орос, Украин, Ойрхи Дорнодод болж байгаа Америк, Израйль, Ираны халуун дайн болон дэлхий нийтийн хүйтэн дайны нөхцөлд эдийн засгийн байдал хүндэрч байна.

Тэгэхээр Та Ерөнхий сайдын хувьд ямар улс орныг үлдээж байна вэ? Үүнийг асууя.

Дараагийн асуулт нь, Та Ерөнхий сайдаар ажилласан хугацаанд эдийн засаг, улс төр, нийгмийн ямар өвийг үлдээв ээ? Үүнийгээ Та дүгнэж хэлээч.

Гуравдугаарт нь, Монгол Улсад энэ зун болох COP17 гээд том хурал болох нь байна. Үүний бэлтгэл хэр хангагдаж байгаа вэ гэсэн энэ гурван асуултыг асууя.

Н.Учрал: Н.Батсүмбэрэл гишүүний асуултад Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Дэлхий дахин дайны нөхцөл байдалтай, учирч мэдэх эрсдэлтэй, дэлхийн дэг журам өөрчлөгдөж соёл иргэншлийн мөргөлдөөн хэлбэрээр дэлхийн энэ дайны нөхцөл байдлыг эрдэмтэн, судлаачид янз бүрээр тайлбарлаж байгаа. Гагц бодит үнэн нь энэ бол дэлхийн эдийн засагт хүн ардын амьдрал, амьжиргаанд шууд нөлөөлж байгаа нь сорилт биш бодит байдал болчихоод байгааг л бид ухамсарлах ёстой болоод байна.

Бодит байдал болсон. Өнөөдөр олон сая хүн амь эрсдэж, дайн тулаан болж, нефть шатахууны үнэ өсөөд дэлхийн бүх эдийн засгийг ер нь хамарч байгаа. Энэ бол бодит байдал. Үүнийг дэлхийн геополитик судлаачид, энэ дэлхийн Монрогийн доктрин (Monroe Doctrine), энэ дэлхийн их гүрнүүдийн бодлого, ааш авир, бүх юмыг тэртээ тэргүй Та бүхэн надаар хэлүүлэлтгүй сайн мэдэж байгаа учраас гадаад орчин хүйтэрч байна гэж би ганцхан үгээр л тодорхойлж байгаа юм.

Ийм учраас дотооддоо Та бүхэн дулаахан байгаач ээ. Өнөөдөр ингээд бүгдээрээ цуглаад ирцээ бүрдүүлж байгаа нь сайхан байна. Энэ хэвээрээ үргэлжлүүлээд ажиллаач ээ л гэж хүсэж байгаа юм.

Би ямар өв үлдээхийг хүсэж байна гэхээр ингэж эв нэгдэлтэй байж байж монголчууд нэг зүгт, нэг чиг рүү харж, нэг монгол болж чадвал бид ямар ч бэрхшээлийг даван туулах ийм эдийн засаг, байгалийн баялаг, бүх юм байна. Эндээ эзэн байх ёстой.

Ийм учраас бид оны эхний 3 сард өмнөх жилүүдээс эдийн засаг, экспорт 30-аас 40 хувь тоон үзүүлэлтүүд бүгд өссөн ийм эдийн засаг хүлээлгэж өгч байгаа.

2025 оны нэгдүгээр улиралд 2.6 хувийн өсөлттэй байсан эдийн засаг 6.8 хувийн өсөлттэй болж, олон улсын байгууллагуудын төсөөллөөс ч өндөр гарсан.

Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбар сэргэсэн. Ноолуурын самнасан ноолуур, боловсруулсан ноолуурын экспорт 4.7 дахин нэмэгдсэн.

2025 онд жуулчдын тоо түүхэн дээд хэмжээндээ хүрч, 847 мянган жуулчин авсан. Эхний 2 сарын байдлаар гэхэд 40 хувиар өндөр жуулчин авч байна.

- Ингээд тооцоод байх юм бол бид төсвөө хэмнэж чадсан.
- Төрийн байгууллагуудад өөрчлөлт хийж чадсан.
- Цэгцрэх хөдөлгөөнийг жигдрүүлээд ямар ч байсан эхлүүлсэн.

Ер нь Монгол Улсын нөгөө хонгилын үзүүрт гэрэл биш гэрэл ассан. Үүнийгээ иргэддээ хүргэх 300 хоногийн төлөвлөгөө бодитой хэрэгжээд эхэлсэн ийм шулуун замдаа орсон. Үүнийг улс төрийн гацаа саад, түгжээ битгий үгүй хийжээсэй гэдэг үүднээс л ийм шийдвэр гаргахад хүрлээ.

Өнөөдрийн бидний улс төржилт хэрээс хэтэрч байна.

Тийм учраас бид тоогоо хараад иргэдийнхээ аж амьдралыг бодож, ард иргэдийнхээ амьдралд наалдацтай бодитой ажил хийх тийм л чиглэл барьж байгаа юм.

Засгийн газрын хуралдаан болгон дээр бид 300 хоногийн төлөвлөгөөг хэлэлцэхдээ иргэдийнхээ амьдралд бодит наалдацтай юмыг хий гэж ажиллаж байсан.

Тийм ч учраас эрүүл мэндийн салбарт бодит ахиц өөрчлөлтүүд гарсан. Боловсролын салбарт бодит ахиц өөрчлөлтүүд гарч байгаа. Хүний хөгжлийн салбарт бодит ахиц өөрчлөлтүүд гарна.

СОР17-гийн хувьд ер нь бол... /минут дуусав/

Н.Учрал: Ерөнхий сайд нэмж хариулна.

Г.Занданшатар: СОР17-гийн ерөнхийлөгчөөр Б.Батцэцэг Гадаад харилцааны сайдыг томилсон байгаа. Үндэсний хорооны даргаар Б.Батбаатар дарга ажиллаж байгаа.

Үндэсний хорооны хурал байнга явж, Засгийн газрын хуралдаанд танилцаж ажиллаж байгаа. Ажлууд урагштай явж байгаа. Тодорхой сааталтай асуудлууд бий.

Дэлхий дахинд өнөөдрийн үүсээд байгаа нөхцөл байдлаас шалтгаалж би уг нь үүнийг даруухан минималист маягаар, тэгээд хамгийн өндөр үр ашигтай, үр дүнтэй зохион байгуулъя гэсэн санаачилгыг сайд нартаа хэлээд ажиллаж байна.

Энэ бол бидэнд бас их үр өгөөжөө өгөх ийм семинар, конференц болох ёстой. Энэ чиглэлээр усны санаачилга, бэлчээрийн санаачилгууд манайх дэвшүүлж ажиллаж байгаа. Би үр дүнтэй болно гэдэгт итгэлтэй байна.

Бодит дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажил нь нийслэл хариуцан ажиллаж байгаа. Энэ бол хэвийн явагдаж байгаа. Би өөрөө очиж шалгасан. Зам, барилгын ажил хэвийн явагдаж байгаа. Зардал бага зарцуулахын тулд шинээр барилга байгууламж бариад хаях биш гурав дахин хямд өртөгтэй түрээсийн арга замаар шийдээд явж байгаа гэх мэтчилэн чиглэл... /минут дуусав/

Н.Учрал: С.Бямбацогт гишүүн үг хэлнэ.

С.Бямбацогт: Сая Ерөнхий сайд хэллээ.

Дэлхийн дэг журам өөрчлөгдөж байна, дэлхий дахин дайны нөхцөл байдалд ажилд амьдрах шаардлагатай болж байна. Өдрөөс өдөрт байдал улам хүндэрч байгаа. Сарын өмнө нэг баррель нефтийн үнэ 67 доллар байсан бол өнөөдөр 120 доллар болж бараг хоёр дахин өссөн байна. Цаашдаа улам хурцдах юм бол 200 долларт хүрнэ.

Нефть бүтээгдэхүүн бүх юмны суурь үнэ байдаг. Үүнийг дагаад бүх бараа, бүтээгдэхүүн нь өсөх ийм маш том эрсдэл бий болж байгаа. Тэгээд энэ цаг үед харамсалтай нь энэ бүхнийг үл тоож, өөр улс төр хийж улсаа бодоогүй, төрөө бодоогүй, ард түмнээ бодоогүй улс төржилт хэрээс хэтэрч өнөөдөр Улсын Их Хурлын үйл ажиллагааг гацаанд оруулж байгаад их харамсаж байгаа.

Монгол Улсын Ерөнхий сайд үүнтэй холбоотойгоор улс төрийн эр зориг гаргаж, улс гэрээ бодож, Монгол Улс үндэстнийхээ нийтлэг эрх ашгийг бодож өнөөдөр улс төрийн шийдвэр гарч өргөдлөө өгч өөрөө чөлөөлөгдөх гэж байна.

Энэ шийдвэр Монгол Ардын намын удирдах зөвлөл, Монгол Улсын Их Хурал дахь Ардын намын бүлэг зөвшөөрч байгаа.

Засгийн газрын кабинетад Засгийн газрын Ерөнхий сайдын гал тогоо барьж ажилласан хүний хэдэн зүйлийг хэлэх ёстой.

Юуны өмнө Засгийн газар Ерөнхий сайд сая хэллээ.

- Эдийн засгийн өсөлт 6.8 хувьд хүрсэн.
- Монгол Улсын валютын нөөц 7 тэрбум доллар болж Монгол Улсын түүхэнд байхгүй өндөр нөөцтэй болсон.
- Монгол Улсын зээлжих зэрэглэл 2012 оны түвшинд, хамгийн өндөр байсан түвшиндээ 14 жилийн дараа хүрч байна.

Ийм өөдрөг үзүүлэлтүүд гарсан.

- Засгийн газарт хэт төвлөрсөн, хөөсөрсөн, зардлаа даахаа больсон, данхайсан төсвийн зардлыг 3 их наядаар бууруулсан.
- Дарга нарын тоог 400-гаар цөөлж, үндэсний хороо, зөвлөл 58 байсныг 29 болгож хоёр дахин бууруулсан.

Улсын төсвийг боловсруулахдаа анх удаагаа ард түмнээсээ асууж 400 гаруй мянган иргэдийн саналыг сонсож байж төсвөө боловсруулж. Мөн багш эмч нарын цалинг түүхэндээ байхгүй хэмжээгээр нэмэгдүүлсэн.

Мөн Зөвлөлдөх ардчиллыг Их Хурлын дарга байхдаа ч хийж анх санаачилж хэрэгжүүлсэн. Өнөөдөр зөвлөлдөх ардчиллыг улс орон даяар эхлүүлж, Баялгийнхаа эзэн монгол байх, монгол хүн байх энэ санал асуулга улс орон даяар зохион байгуулж байна.

Хийсэн ажлаа хэрэгжүүлэх зорилт, асуудал бэрхшээлээ, шийдвэр шийдлээ ард түмэндээ тайлагнадаг Ерөнхий сайд байсан.

Энэ индэр дээрээс 14 хоног болгон Их Хурлын гишүүдтэйгээ мэтгэлцээн хийж, хийж байгаа ажил, болж байгаа болохгүй бүх зүйлээ илэн далангүй нээлттэй ярьдаг ийм Ерөнхий сайд байсан.

Монголын ард түмэн байгалийн баялгаасаа өртэй үлдэх биш өв хүртдэг байх бодлогыг хэрэгжүүлж, санаачилж, эхлүүлж Оюу Толгойн хөрөнгө оруулагч талд хатуухан шаардлага тавьж, ард түмнийхээ эрх ашгийн талд бат зогсож, зоригтой үгээ хэлж тодорхой үр дүн гаргаж байсныг хажууд нь байсан хүний хувьд би бас ам бардам хэлнэ.

Монголчууд стратегийн орд газруудаасаа 60-аас доошгүй хувийн өгөөж хүртдэг байх хэлцлийг хувийн хэвшлийнхэнтэйгээ ярилцаж, ойлголцож хэлэлцээрийн шинэ ард сууж, Монголын ард иргэддээ, Монголын төрдөө ашигтай хэлцлийг эхлүүлсэн. 20 жил гацсан ажил тодорхой үр дүн гарч байгаа.

Мөн 40 жил яригдсан зэс хайлуулах үйлдвэр. Энэ стратегийн хөрөнгө оруулалт шалгаруулж зэс хайлуулдаг анхны томоохон төсөл хэрэгжих энэ ажил эхлээд явж байгаа. “Эрдэнэс Тавантолгой”-н нүүрсний хулгайтай холбоотой 581 гэрээг ил тод олгох ажлыг хийж хэрэгжүүлсэн гээд олон зүйлийг хийж хэрэгжүүлсэн.

Тийм болохоор энэ эхлүүлсэн ажлыг цаашдаа үргэлжлүүлж ажиллах ёстой. Ерөнхий сайдыг кабинетдаа багтааж ажилласанд талархлаа илэрхийлье.

Н.Учрал: У.Отгонбаяр гишүүн асуулт асууна.

У.Отгонбаяр: Та бүгдэд энэ оройн мэндийг хүргэе.

Би ноолуурын салбарын талаар Ерөнхий сайдаас асуулт асуух гэж байна.

Яагаад гэвэл яг энэ цаг мөчид Монгол Улсын хэмжээнд тэр дундаа малчид маань ямаагаа самнаж ноолуураа цуглуулж байгаа.

Ноолуур зүүн бүс нутгаас эхэлдэг. Монгол Улс дэлхийн түүхий ноолуурын 40 орчим хувийг Монгол Улсаас гардаг. Ноолуур гэдэг түүхий эд манай малчдын маань санхүүгийн гол эх үүсвэр. Би яагаад энэ асуултыг асууж байна гэхээр цаашдаа Засгийн газрын ноолуурын салбарт дунд, урт хугацааны бодлогыг Та өнгөрсөн болон одоо цаг дээр бас нэг мэдээлэл өгөөч.

Би яагаад үүнийг тодруулж асууж байна гэхээр жишээ нь маргааш нөгөөдөр манай Сүхбаатар аймагт Монгол Улсын Засгийн газар ноолуурын дуудлага худалдааг эхлүүлэх гэж байна. Энэ өөрөө маш чухал зүйл.

Тийм учраас цаашдаа төрийн бодлогын залгамж чанар цаашаа үргэлжлэх ёстой гэж Та хэлж байна. Энэ ноолуурын бодлогоор ноолуурын салбарын бодлогыг Та тодорхой өнөөдөр энэ индэр дээрээс хэлж өгөөч. Яагаад гэвэл үдээс хойш Монгол Ардын намын Удирдах зөвлөлийн шийдвэр гарсан. Тэрнээс хойш орон нутгаас нэлээдгүй малчид мессеж бичиж утсаар тодруулж байна. Энэ дуудлага худалдаа маань үргэлжлээд явах юм уу? Энэ ноолуурын салбарын бодлого цаашаа үргэлжлэх юм уу гэдэг энэ асуултуудыг асууж байна.

Түрүүн би дурдсан. Манай зүүн бүс нутаг маш сайн ноолууртай. Хэнтий, Дорнод, Сүхбаатар. Тэр дундаа манай Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын улаан ямааны ноолуур дэлхийд нэлээн дээгүүрт ордог ийм ноолуур.

Тийм учраас энэ салбарын дунд урт хугацааны бодлогын талаар Та мэдээлэл өгөөч гэж хүсэж байна.

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Улсын Их Хурлаар баталсан “Цагаан алт” хөтөлбөр амжилттай хэрэгжиж манай ноолуур боловсруулах хүчин чадал 5 дахин нэмэгдэж, манай ноолуурын үйлдвэрлэл бодит хэмжээгээрээ 5.7 дахин, үнийн дүнгээрээ 4.7 дахин. Экспортын ингэж нэмэгдсэн.

Энэ бол малчин ардын амьдралд төдийгүй нийт хөдөөгийн хөгжилд маш чухал үүрэгтэй. Яагаад гэвэл малчдын орлогын 50 хувь нь мах, 40 хувь нь ноолуур байдаг.

Ийм учраас энэ ноолуурыг үнэд оруулах, ноолуураа боловсруулах хүчин чадлыг сайжруулах ийм цогц бодлого хэрэгжүүлэх зорилгоор ноолуур үйлдвэрлэгчидтэй М.Бадамсүрэн сайд бид хоёр хэд хэдэн удаагийн уулзалтууд хийсэн.

Энэ чиглэлээр зохих дэмжлэгүүдийг үзүүлж ажиллаж байгаа. Ийм ч учраас зүүн бүсэд ноолуур гарах үед ноолуурын дуудлага худалдааг зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Энэ бол нэг талаасаа ноолуурынхаа чанарыг сайжруулъя. Нөгөө талаасаа ноолуур үйлдвэрлэгчид, малчид хоёрыг шууд холбоё. Дундын ченжгүйгээр малчдынхаа орлогыг нэмэгдүүлдэг ийм шинэ хэлбэр бол ноолуурын дуудлага худалдаа. Уламжлалт хэлбэр.

Ингэж зохион байгуулах гэж шийдвэрлэсэн. Энэ бол хэвээрээ үргэлжилнэ. Манай Хүнс, хөдөө аж ахуйн сайд оролцоно. Мэдээж бид оролцох боломжгүй байгаадаа хүлцэл өчье. Уучлал хүсье. Тэгэхдээ тэнд манай үйлдвэрлэгч нар бүгд очих юм байна лээ.

Төв аймгаас хүртэл ноолуур очиж байна гэсэн мэдээлэл байна. Зүүн бүсийн ноолуур сайн учраас, эрт гардаг учраас. Баяндэлгэр, Дорнодын хойд бүсийн ноолуур хог хаягдал, тоос шороо багатай, ер нь ноолуурын гарц өндөртэй, чанар сайтай ноолуур өндөр гарна.

Ийм учраас яах вэ, тодорхой үнэ зардал ч хэрэггүй. Буруу хүлээлт үүсгээд бас олон хүн цуглаад ноолуураа үнэгүйдүүлж байсан гашуун туршлагыг давтах ёсгүй. Энэ жил 185 орчим мянгаар ноолуур гаргах төсөөлөлтэйгөөр бид ажиллаж байсан. Ажиллаж байгаа. Ингэвэл ноднин жилээсээ малчдын орлогод. Энэ 40 хувийг нь борлуулдаг орлого дээр махны үнийг нэлээн нэмэгдүүлж малчдын орлого нэлээн нэмэгдсэн. Одоо ноос, ноолуурынхаа үнийг нэмэгдүүлснээр 300 мянган малчдын амьдрал, түүнтэй хамт хөдөө орон нутгийн сая гаруй хүний амьдрал ахуйд эергээр нөлөөлнө.

Ингээд ноолуураа боловсруулж гаргах хүчин чадлуудаа сайжруулна. Ахиад нэг шат нэмэгдүүлээд одоо ээрэх хүчин чадлаа нэмэгдүүлж чадах юм бол Монгол Улсын дэлхийн зах зээлд гол тоглогч болж чадах ёстой. Италийн том том брэндүүд, “Logo Piana” гэх мэтчилэн том брэндүүд манайх ноолуур эхэлж болж байгаа. Маш том ахиц амжилтууд гарч байгаа.

Ийм учраас энэ жил 350 орчим төгрөгийн зээл олгохоор хөнгөлөлттэй зээл олгож байна. Үндсэндээ 1 их наяд орчим төгрөгийн түүхий ноолуур бэлтгэгддэг энэ зээлийн схемийг хэрэгжүүлж байгаа.

Дуудлага худалдаа 20-ны өдөр аймгийн төв зохион байгуулагдана. Манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам байнга л тэгж ажиллаж байгаа.

Н.Учрал: Тогмидын Доржханд гишүүн үг хэлнэ.

Т.Доржханд: Баярлалаа. Би санаж л байна л даа.

Яг нэг жил хүрэхгүй хугацааны өмнө би яг энд үг хэлж байсан. Хамгийн сүүлийн үг. Тэр нь Л.Оюун-Эрдэнийн тэргүүлсэн Монгол Ардын нам, Ардчилсан

нам, ХҮН намын орсон хамтарсан Засгийн газрыг би өмгөөлж үг хэлж байсан. Яг одоо би бас өнөөдөр Г.Занданшатар гэж хүний тэргүүлсэн Монгол Ардын нам, ХҮН нам, Иргэний Зориг Ногоон намын хамтарсан Засгийн газрыг бас хамгаалж үг хэлье гэж бодож байгаа.

Ардын намынхан сайн сонсох хэрэгтэй. Тэгээд гар утсаа харж байгаа Ардчилсан намынхан сайн сонсоорой.

Тэгэхээр юу вэ гээд гэхээр яагаад бид өнөөдөр энд байгаа юм бэ, ХҮН нам Засгийн газарт байгаа юм бэ гэхээр нэг л зүйл байгаа.

Кабинетын зарчмаар бид ажилласан, ажиллана, ачаа үүрнэ гээд, юуны төлөө вэ гэхээр тогтвортой байдлын төлөө л бид энд байгаа. Бид шүүмжилж болно, харлуулж болно, юу ч гэж ярина. Тэгэхдээ Монгол Улсын эрх ашгийн төлөө бид энд байсан юм шүү.

Ардын намын маш олон гишүүд манай сайд нарыг, ялангуяа Боловсролын сайдыг маш буруу мэдээлэлтэйгээр гүтгэсэн. Бид чимээгүй л байсан. Ардчилсан намынхан гүтгэсэн. Чимээгүй л байсан. Кабинетын зарчмаа барьсан.

Бид Ардын намын нэг ч сайдын асуудлыг бид хөндөөгүй. Дотроо ярьж байгаад тэгээд асуудлаа дотроо ярьдаг л байсан. Энэ институц байсан.

Яагаад ингэсэн юм бэ гэхээр, яагаад вэ гэхээр Монгол Улс том газар нутагтай, цөөхөн хүн амтай, дэлхий дээр ийм том газар нутагтай цөөхөн хүн амтай улс хөгжсөн түүх байхгүй ээ. Хоёрхон л байдаг юм. Канад, Австрали. Газар нутгийнхаа 2 хувь дээр л дэд бүтцээ төвлөрүүлдэг юм.

Гэтэл Монгол Улс нийт газар нутаг дээрээ дэд бүтцээ төвлөрүүлдэг болохоор асар их зардалтай. 70 жил бид Оросуудаас мөнгө аваад шийдэж чадаагүй юм. 10 тэрбумд шилжих рублийн өртэй үлдсэн байдаг юм. Цаанаа бас өртэй. 35 жил бид төсвөөрөө шийтгээд чадаагүй байнгын алдагдалтай. Боломжгүй. Дэлхий дээр ийм улс байдаггүй юм.

Яагаад вэ гэхээр ийм их дэд бүтцийн хэрэгцээтэй. Үүнийг бид хэзээ ч төсвөөрөө шийдэж чадахгүй. Үүнийг шийдэхийн тулд бид гадна дотнынхоо хөрөнгө оруулалтыг татаж, бизнесүүдээ дэмжих байдлаар л шийдэх боломжтой юм.

Манайх дэндүү жижигхэн эдийн засагтай. Дэндүү боломжтой мөртлөө өгөгдөл нь маш муу. Хуурай, хүйтэн. Бизнес эрхлэхэд тааламжтай биш. Хоёр хөрштэй. Далайд гарцгүй. Үнэн.

Хойноо өнөөдөр дайнтай. Урд талдаа тарифын хязгаарлалттай. Одоо ингээд дэлхий даяараа нефтийн өндөр үнийн өсөлттэй, дэлхий даяараа

инфляцын асуудалтай маш хүнд хэцүү цаг үе байна. Энэ бол өнөөдрийн Монголын бодит байдал.

Хаалга тогшоод цаана нь хөрөнгө оруулалт хийж байгаа нэг ширхэг ч бизнесмен байхгүй. Хөрөнгө оруулагч байхгүй.

Дотоодын бизнесүүд чинь нэг жилээс илүү төлөлт хийж чадахгүй. Яагаад гэвэл төсөв чинь өөрөө байнга тодотгодог. Дунд хугацааны тодорхой төлөлт байхгүй. Яагаад вэ гэхээр Засгийн газар нь байнга өөрчлөгддөг. Хэн ийм улсад хөрөнгө оруулж, хэн бизнес хийх юм бэ. Боломжгүй. Хөгжих ямар ч боломжгүй. Энэ байдлаараа бол.

Хэн мундаг Ерөнхий сайд байна гэдэгтээ биш шүү. Хэн тогтвортой Засгийн газар үүсгэж чадаж байна гэдэг рүү л мөнгө орж байгаа, бизнес орж байгаа, тэнд амьдрал явж байгаа.

Гэтэл бид энэ боломжийг хаагаад байна.

Ардын намынхан. 105 жилийн түүхтэй Ардын намынхан маань хоёр удаа ингээд Засгийн газар огцруулах үйл ажиллагааг өөрсдөө гардан зохион байгуулсан шүү.

Ардчилсан намынхан маань мөн адилхан энэ дээр улс төрийн хонжоо хайж байна. Парламентын ардчилал яриад байна. Үгүй тэгээд 1996-2000 оныхоо парламентыг хар л даа. Засаг нь 4 удаа огцорсон. Парламентын нэр хүнд маш их унасан шүү дээ. Яагаад гэвэл парламентаас түрэн гарч байгаа тэр Засгийн газар чинь тогтвортой байж энэ чинь нэр хүндтэй байх ёстой байх. Унагаад, унагаад, унагаад тэгээд үр дүн нь юу байх юм бэ.

Тийм болохоор энэ Засгийн газар сайн ажилласан. Өмнөхөн ч бас хичээж ажилласан. Хамгийн гол нь тогтвортой байдал чухал шүү гэдгийг дараагийн Засгийн газраа... /минут дуусав/

Н.Учрал: Т.Доржханд гишүүн үг хэллээ.

Монгол Улсын 34 дэх Ерөнхий сайдаар ердөө 9 сарын богинохон хугацаанд ажиллахдаа нүүрсний экспортыг 3 дахин нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг 6.8 хувьд хүргэж, улсын төсвийг 2.3 их наядар танаж, гадаад валютын нөөцийг түүхэнд анх удаа 7.1 тэрбум долларт хүргэсэн олон бодит үр дүнтэй ажлуудыг Гомбожавын Занданшатар Ерөнхий сайд манлайлж хэрэгжүүлсэн.

Албан тушаалаас илүү ард түмэн, улс орны язгуур эрх ашгийг эрхэмлэн дээдэлж, парламентын гацааг тайлж, Улсын Их Хурлын хэвийн үйл ажиллагааг хангах, хууль бус ажил хаялтыг зогсоох, төрийн хүний зангараг, ноён нуруу харуулсан таны үйлдэл ёс зүй үлгэр дуурайлал болж цаашид Монголын улс төрд ёс зүйн өндөрлөг болж тэмдэглэгдэн үлдэнэ гэдэгт итгэлтэй байна.

Монгол Улсын 34 дэх Ерөнхий сайд танд цаашдын төр улсын төлөөх үйл хэрэгт өндөр амжилтыг хүсье.

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж үг хэлж дууслаа. /алх цохив/

Үргэлжлүүлээд хуралдааныг Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ удирдана.

Ж.Бат-Эрдэнэ: Одоо Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар Танд үг хэлнэ үү гэж индэрт урьж байна.

Г.Занданшатар: Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дарга аа, Улсын Их Хурал, Засгийн газрын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ард иргэд ээ,

Та бүхэндээ энэ үдшийн мэндийг хүргэе.

Монголчууд бид дэлхийн дайн, геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалсан түлш, шатахууны хомсдол, цахилгаан эрчим хүчний хүндхэн хязгаарлалт, санаанд оромгүй олон сорилт⁸ бэрхшээлүүдтэй нүүр тулсан ч Монгол төр, Монголын ард түмэн хамтын хүчээр энэ бүх бэрхшээлийг даван туулж, бат зогсож чадсанд бид гүнээ талархаж байна.

Энэ бүхнийг даван туулахын төлөө хамтран ажилласан, хичээн зүтгэсэн Засгийн газрын эрхэм гишүүд, Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд Та бүхэндээ чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Энэ үдэш төрийн жолоог барилцаж буй Та бүхэн маань ингээд яаралтай цуглаад асуудлаа хэлэлцэж байгаа нь улс орны нөхцөл байдал энгийн горимоос гажиж улаан шугамаа давж байгааг тод анхаарч ажиллах итгэл найдварын эхлэл гэж бодож байна.

Дэлхийн дэг журам өөрчлөгдөж, геополитикийн хурцадмал мөргөлдөөн хямралын ирмэгт тулсан амаргүй цаг үе дэлхий дахинд тулаад байна.

Ийм цаг үед бид дотооддоо талцах биш дэлхийн шуурганд хамтдаа сөрөн зогсох нэг Монгол байх ийм цаг ирсэн. Гэтэл өнөөдөр улс төрийн талцал хэтэрч, төрийн шийдвэр гаргалт саарч, үүний хүнд ачаа ард иргэдийн амьдрал дээр шууд бууж байна.

Монголд ёс зүй байхгүй бол итгэл үгүй, итгэл үгүй бол, төр, засагтаа итгэх итгэл үгүй бол засаглал үгүй болно.

Илтгэл алдарсан газарт дархан ирэх нь давуу эрх болж хувирдаг гэмтэй.

Өнөөдөр эрх мэдлийн шунал хүсэл хяналтгүй болж, намын хуваагдал, зөрчилдөөн төрийн хямрал болж, цаашлаад энэ дэлхийд шившиг болж байна.

Хаяа нь хагархай айл шиг ёс зүйн хэм хэмжээнээсээ давж, төр улс нь үндэстэндээ ийм буруу үлгэр дуурайлал үлдээх нь гаж мөр үлдээж улс төрчид хязгааргүй их мөнгөөр засаг төрөөр тоглодог жишиг тогтоож байна гэж үздэг. Үүнд бид гүнээ харамсаж байна.

Бид энэ ёс зүйн уналтыг зогсоохгүй бол энэ улс төр өөрөө ард түмний эсрэг систем болж хувирна. Ийм учраас бид төрийн хүний хувьд ёс зүйн өндөрлөгт байх яруу жишиг, үлгэр дуурайл үзүүлж ийм санал, санаачилга гаргаж энэхүү шийдвэрийг гаргалаа.

Энэ ханан дээр ч гэсэн байдаг. Алд бие минь алжааваас алжаатугай, ахуй төр минь бүү алдартугай гэдэг Эзэн Чингис хааны үг бол бидний өглөө болгон санаж байх ёстой эрхэм сургаал, ягштал баримтлах дэг журам мөн гэж бодож байна.

9 сарын өмнө Та бүхний итгэл, ард түмний захиалгаар Монгол Улсын Ерөнхий сайдын хариуцлагатай албыг хүлээж авахдаа би нэг зүйлийг тодорхой хэлж байсан.

Гадаад тал хэцүү байна, хямрал мөргөлдөөний сөрөг нөлөөллийг ард иргэддээ үүрүүлэхгүй, төр өөрөө бүсээ чангална гэж ажил авсан өдрөө мэдэгдэж төсвийн тодотгол хийсэн.

Өнөөдөр би энэ унаад байсан эдийн засгийг өөд нь татахын төлөө, Та бүхний өмнө энэ амлалтад хүрэхийн төлөө хийсэн ажлаа товчхон ч гэсэн тайлагнаж, хамтдаа туулсан замаа дүгнэх ёстой гэж үзэж байна.

Манай Засгийн газар эдийн засгаа хямралаас сэргэлт рүү шилжүүлж бодитой өөрчлөлтүүдийг авчирч чадсан гэдгийг тоо баримтууд нотолж байгаа.

Биднийг Засгийн газрыг хүлээж авах үед –

- нүүрсний үнэ унасан,
- экспорт хумигдсан,
- валютын нөөц багассан,
- инфляц өссөн,
- эдийн засгийн өсөлт 2.6 хувь хүртэл буурч саарсан байсныг Та бүхэн санаж байна.

Хэрэв бид цаг алдалгүй шийдвэр гаргаагүй бол, наадмаас өмнө нэн хурдтай үүнийг зориг гарган шийдээгүй бол инфляц 15 хувь хүрч, долларын ханш

4 мянган төгрөг хүрч сулрах, төлбөрийн тэнцэл 1 тэрбум долларын алдагдалд орох бодит эрсдэл нүүрлэсэн байсан.

Гэвч бид зайлшгүй сонголтыг хийсэн. Ард түмний халаасыг тэмтрэх биш төр өөрөө бүсээ чангалсан.

Ингээд Монгол Улсын түүхэнд анх удаа 2.2 их наядаар төсвийн хэмнэлтийн тодотгол хийсэн.

Үүний үр дүнд –

- нүүрсний экспорт 90 сая тоннд хүрч, нийт экспортын орлого 15.8 тэрбум долларт хүрлээ.
- Ноолуурын экспорт 332.0 сая долларт хүрч самнасан ноолуурын экспорт 4.7 дахин өслөө.
- Махны экспорт 25.7 өслөө.
- Жуулчдын тоо 720 мянгаас 847 мянга хүрч түүхэн дээд хэмжээний жуулчид авлаа.
- Ингээд эдийн засгийн өсөлт 2.6 хувиас 6.8 хувь болж нэмэгдлээ.
- Инфляц 9.3-аас 8.3, улмаар 6.5 хувь болж буураад байна.
- Төлбөрийн тэнцэл 600.0 сая долларын алдагдалтай байсан бол одоо 1 тэрбум долларын ашигтай боллоо.
- Валютын нөөц түүхэн дээд хэмжээндээ буюу 7.1 тэрбум долларт хүрч 2.1 тэрбум доллароор нэмэгдлээ.

Энэ бол зөвхөн тоо биш зөв бодлогын үр дүн юм. Үүнийг зөвхөн дотоодын тоо баримт биш дэлхийн нэр хүнд бүхий гол гурван үнэлгээний байгууллага гурван өөр өнцөг, аргачлалаар үнэлээд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулж, тогтвортой зэрэгт шилжүүлсэн нь 2012 оноос хойш сүүлийн 14 жилд хүрч байгаагүй өндөр үзүүлэлт юм.

Манай Засгийн газар том төрөөс чадварлаг төр лүү шилжих эхлэлийг тавьж, хариуцлагын шинэ соёлыг бий болголоо.

Яамдын бүтцийг 81 нэгжээр өөрөөр хэлбэл газар хэлтсээр цомхотгосон. Агентлагийн удирдлагыг 54-өөр, 29 зөвлөл, хороог татан буулгаж, төрийн өмчийн компанийн удирдлагыг 200-гаар бууруулж, 55 төрлийн зөвшөөрлийг хүчингүй болгож, хил гаалийн шат дамжлагыг 40 хувиар цөөллөө.

Төрийн зарцалсан өмчүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулж, иргэдэд буцаан ашиглуулах шийдвэрүүдийг хэрэгжүүллээ.

Ингэж бид төр булаагч биш чөлөөлөгч байх ёстой гэдгийг бид бодитой хэрэгжүүлсэн.

“Эрдэнэс Тавантолгой” дээр онцгой дэглэм тогтоож ердөө 2 сарын дотор борлуулалтыг 1.6 дахин өсгөсөн.

Өнөөдөр үүний үр дүнд нүүрсний экспорт огцом нэмэгдэж, биржийн арилжаа хэт их өссөн. Үүнийгээ дагаад үр ашиг нь нэмэгдсэн.

Энэ бол бодит баримтууд. Тоо худлаа хэлдэггүй.

Төр зөв үед зөв оролцвол үр ашиг бий болдог гэдгийг энэ харууллаа. Энэ бол цэгцтэй зөв бодлого үр ашгийг сайжруулдгийг харуулсан яруу тод жишээ юм.

- Манай Засгийн газар нийгмийн аюулгүй байдлыг хангах хүрээнд ч гэсэн хар тамхитай гэмт хэрэгтэй тэмцэх тусгай мэргэшсэн албыг байгууллаа.
- Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг тууштай хэрэгжүүлж “Баялагтаа эзэн Монгол” зорилтыг үгээр биш үр дүнгээр хэрэгжүүлж эхэлсэн.
- Төгрөг нуур, Төмөртэйн орд, Төмөртэйн овоо зэрэг стратегийн ордуудыг төрд буцаан авч өгөөжийг нь ард түмэнд хүртээх ажлыг эхлүүллээ.
- Оюутын шинэ орд 357 сая тоннын зэсийн нөөц илэрснээр Эрдэнэт үйлдвэр тэжээлийн цэгийн үнээ биш ахиад 100 жил тогтвортой ажиллах бат бөх суурийг тавилаа. Энд зэс хайлуулах үйлдвэр бодит ажил хэрэг болон хэрэгжиж эхэллээ.
- Эрдэнэт тэжээлийн цэгийн үнээ биш зуун дамнах баялгийн эх ундарга гэдгээ нотолж, зэсийн үйлдвэр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүнийг олон хувиар нэмэгдүүлэх ийм бодит салбарыг эхлүүллээ.
- Төрийн өмчит салбарт цэгцрэх хөдөлгөөн амжилттай хэрэгжиж “Эрдэнэс Монгол” нэгдэл 12.8 их наядын төгрөгийн орлого, 4.5 их наяд төгрөгийн ашиг, 4 их наяд төгрөгийн татвар төвлөрүүлээ.

Энэ бол цэгцтэй зөв бодлого, төр зөв удирдвал баялаг бүтээж чаддаг гэдгийн бодит нотолгоо мөн.

Мөн “Баялагтаа эзэн Монгол” үндэсний зорилтыг хэрэгжүүлэх бодит алхам эхлүүлсэн. Бид баялгийн бодлогыг үгээс бодит ажил болгосон. Хамгийн тод жишээ нь Бортээг.

Бортээгийн ордыг бид ил тод, нээлттэй өрсөлдөөнт зарчмаар эдийн засгийн эргэлтэд оруулах шинэ зарчим, шинэ аргыг нэвтрүүлж тууштай зарлалаа.

Монголын өгөөжийг 51 хувиас бууруулахгүй зарчим баримталж олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтыг анх удаа хэрэгжүүлсэн.

Өнгөрсөн 9 сарын хугацаанд бид баялгийн бодлогын үгээс ийм бодит ажлуудыг болгосон. Өнөөдөр Бортээгийн ордод хөрөнгө оруулахаар 7 компани хүсэлтээ ирүүлж, 500 саяас 1 тэрбум ам.долларын урьдчилгаа төлбөрийн санал ирүүлээд байна.

Энэ бол зах зээлийн үнээр, биржийн үнээр хийгдэх арилжаа. Энэ нэг зүйлийг тод харуулж байна. Монголын баялаг үнэгүй биш зөв ашиглавал дэлхийд үнэлэгддэг болохын нотолгоо юм.

Түүнчлэн олон жилийн турш яригдаж буй Оюу Толгойн ордоос Монголын ард түмэнд хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд манай Засгийн газар хатуу байр суурь баримталж, тодорхой тооцоо, судалгаатай ажилласны үр дүнд бодит үр дүнд хүрч байна.

Тухайлбал,

- ▶ Монголын ард түмний хүртэх өгөөжийг 60 хувиас доошгүй болгож нэмэгдүүлэх,
- ▶ ногдол ашгийг 2026 оноос эхлүүлж урьдчилгаа ногдол ашгийг авах,
- ▶ зээлийн хүүг 5-аас 6 хувь болгон бууруулах,
- ▶ менежментийн төлбөрийг доор хаяж хоёр дахин бууруулах –

гэсэн 5 үндсэн хатуу шаардлагыг тавиад яриа хэлэлцээр амжилттай өрнөж байна.

Бид нэг зүйлийг тодорхой хэлсэн. Баялгийн дийлэнх өгөөж Монголын ард түмэнд очих ёстой.

Хэлэлцээр ид үргэлжилж байна. Гэхдээ бидний зарчим өөрчлөгдөх ёсгүй гэдгийг бид энд цохон тэмдэглэж байна.

Манай Засгийн газар үндэсний баялгийн бодлого, тогтолцооны өөрчлөлтийг бодитойгоор хэрэгжүүллээ. Тухайлбал, стратегийн ордуудын төрийн эзэмшлийн хувь өгөөжийг тодорхой болгох хэлэлцээг эрчимжүүлж, хувийн хэвшил, төр ард түмэн бүгд хожих зарчимд тулгуурласан шинэ загварыг эхлүүллээ.

Томоохон ордууд дээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудтай хийсэн хэлэлцээний үр дүнд баялгийн өгөөжийн доод хэмжээг 60 хувиас бууруулахгүй байх зарчмын тохиролцоонд хүрлээ.

Өгөөж буурсан тохиолдолд нөхөн төлөх механизмыг бий болгож баялгийн татвар хэлбэрээр хэрэгжүүлэхээр тохиролцлоо.

Бид стратегийн ордыг өмчлөх тухай биш харин баялгийн өгөөжийг ард түмэнд хамгийн өндөр хэмжээнд хүрэх тухай бодлогыг ингэж бодитой хэрэгжүүлж байна.

Өөрөөр хэлбэл төрийн шууд эзэмшлийг илүү үр ашигтай, ил тод, зах зээлтэй уялдсан ашигт малтмалын төлбөр, өгөөжийн шинэ тогтолцоогоор орлуулах шийдлийг боловсруулсан.

Энэ бол –

- баялаг,
- төсөв,
- иргэн гэсэн шинэ тогтолцооны эхлэл юм.

Манай Засгийн газар эдийн засгийн сэргэлтийг иргэдийн амьдрал, айл өрхийн үүд хаалгаар оруулахын тулд хичээн ажиллаж байна. Зарим үр дүнгээс товч дурдвал өрхийн бодит орлого 5 хувь өсөж, аялал жуулчлалын тоо 847 мянга болж, 728 сая долларын орлого оллоо.

Эрүүл мэндийн салбарт тэр дундаа өдөрт 600 байсан “улаан бурхан” өвчний халдварын эсрэг дархлаажуулалтыг 95 хувь хүргэж өвчлөлийг зогсоолоо.

Энэ бүхэн тоон үзүүлэлтүүд биш энэ аврагдсан амь, хамгаалагдсан ирээдүй, монгол хүний амьдралын чанарын өөрчлөлт юм.

Мөн хөдөө орон нутагт хавдрын оношилгоо, эмчилгээний үйлчилгээ ойртож, эрчим хүчний салбарыг өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлж, үр ашгийг нь сайжруулах цогц бодлого хэрэгжиж байна.

Эрхэм гишүүд ээ,

Өнгөрсөн 9 сарын хугацаанд манай Засгийн газар дараах 5 суурь үр дүнд хүрлээ.

- ➔ Эдийн засгийг хямралаас гаргаж, өсөлтийг 6.8 хувьд хүргэснээр цаашдын солонгорсон эдийн засгийн суурь бүтцийг эхлүүллээ.
- ➔ Данхар төрийг цэгцлэх шинэчлэлийг эхлүүллээ.

- Баялгийн бодлогын шинэ стандарт тогтооллоо.
- Хөрөнгө оруулалтын орчныг сэргээлээ.

Иргэдийн амьдралд мэдэгдэхүйц бодит өөрчлөлтийг авчрах 300 хоногийн төлөвлөгөөг амьдралд наалдацтай хэлбэрээр хэрэгжүүлж байна.

Бид системийн өөрчлөлтийн суурийг ингэж тавьж эхлүүлээ. Харин түүнийг гүнзгийрүүлэх ажил цаашдаа тууштай, залгамж чанартай үргэлжлэх ёстой.

- Бид эдийн засгийн хямралыг давсан.
- Бид ард түмнийхээ итгэлийг сэргээсэн.
- Бид шинэ боломжуудын үүдийг нээсэн.

Бид бүхний амжуулж чадаагүй олон ажлууд бай байж болно. Гэхдээ бид нэг зүйлд үнэнч байсан. Энэ бол Монгол Улсын язгуур эрх ашиг, Монголын ард түмний итгэл, өргөсөн тангараг.

Энэ бол төгсгөл биш энэ бол шинэ эхлэл.

Ийм ч учраас бид ирэх 5 жилд улсаа хөгжүүлэх шинэ итгэл, эрс шинэтгэл, 5 жилийн үндсэн чиглэлийг тодорхой шалгуур, хэмжих үзүүлэлтүүдтэйгээр бодитой хэрэгжүүлж, өдөр тутмаар төлөвлөж, хэмжиж, хэрэгжүүлж, хянаж ажилладаг системийг тогтоон ажиллаж мөрдөж байна.

- Монголын баялаг монгол хүндээ үйлчлэх ёстой.
- Монголын төр Монголын иргэндээ үйлчлэх ёстой.

Ингээд 9 сарын өмнө өгсөн амлалтаа бид өнөөдөр Та бүхэндээ товчхон тайлагнаж байна.

Хийсэн ажил их байна. Дараа дэлгэрэнгүй тайлагнах боломж олдоно гэдэгт итгэж байна.

- Хийх ажил их байна.
- Хүрэх зорилго өндөр байна.

Гэхдээ бид нэг зүйлийг нотолсон. Монгол Улс зөв бодлогоор цэгцтэй цэгцрэх хөдөлгөөнөөр урагшилж чадна аа.

Эрхэм гишүүд ээ,

Бид ажлаа хийсэн. Гэхдээ надад, бидэнд энэ тоо баримтаас илүү Монгол төрийн систем, Монгол төрийн ёс зүй өөрөө чухал байна.

Бид энэ хямарч гажуудсан бүхнийг цэгцлэхийн тулд “Цэгцрэх хөдөлгөөн”-ийг эхлүүлсэн. Энэ бол нэг хүний биш Монгол төрийг шинэ шатанд гаргах түүхэн оролдлого байсан юм.

Төр нь иргэнээсээ холдсон, авлигад идэгдсэн, шийдвэр гаргаж чаддаггүй энэ тогтолцоог халах нь бидний туйлын зорилго байлаа.

Бид ялагдал, талцал, хуваагдал, парламентын гацаа, улс орны чухал шийдвэрүүдийг зогсоож, гадаад дайны халуун цэгээс дутахааргүйгээр нэрвэгдүүлж эхэлсэн байна.

Улс төрийн институцүүдийн хуваарилалтад маргалдаж байх зуур улс орны эдийн засагт нурж мэдэхээр ийм аюул ойртсон байна.

Ард түмний итгэл үнэмшлийг шударга сэргээж, ардчиллын үнэт зүйлсийг олон түмний оролцоо бэхжүүлж байдаг гэдгийг бид огт мартаж болохгүй.

Энэ бүх маргаан эрх мэдлийн төлөөх улс төрөөс илүү монгол хүний аж амьдрал чухал. Төр нь гацаж, төрийн түшээд нь улс төрийн ашиг хонжооны төлөө гүтгэлэг, дайралтаар нийгмийн сэтгэл зүйд гүн хямралд чирч байгаа нь ард түмний нуруунд хүнд ачаа болж байна.

Монголд хүн засагладаггүй хууль засагладаг байх ёстой. Задарсныг нь засагладаг, ядарсныг нь хайрладаг төртэй байх ёстой. Ийм төр байсан, одоо ч байна, цаашдаа ч байх учиртай. Энэ бол Монголын төр өө.

- Төр зогсох ёсгүй.
- Төрийн бодлого тасалдах ёсгүй.
- Төрийн үйл ажиллагаа саатах учиргүй.

Монгол Улс урагшилсаар байх ёстой. Би явж болно. Харин шударга үнэний төлөө тэмцэл хэзээ ч зогсох ёсгүй. Монголын төрийн үйл ажиллагаа тасарч болохгүй.

Энэ чөдөр тушааг тасдахын тулд би өөрөөсөө эхэлж байна.

Би ийм учраас Ерөнхий сайдын албан тушаалаас өөрийн хүсэлтээр татгалзаж байна.

Улс төрийн өрнөл үйл явдлыг дэлгэрэнгүй тайлбарлах боломж хожим олдоно гэдэгт итгэж байна. Албан тушаал мөнх биш. Харин Монголын төр мөнх юм.

Улс төрийн тэмцлийн золиос нь ард иргэд багасдаггүй. Бидний эхлүүлсэн өөрчлөлт үнэн зөв эцэстээ заавал ялна.

Төр түвшин, дэлхий ертөнц амгалан байх болтугай.

Мөнх хөх тэнгэрийн хүчин доор Монгол Улс маань мандан бадрах болтугай. /алга ташив/

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар Танд баярлалаа.

Одоо Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарын үүрэгт ажлаас чөлөөлөх асуудлаар ил санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлдье. /алх цохив/

Гомбожавын Занданшатарын гаргасан Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 126 гишүүнээс 76 гишүүн оролцож, 73 гишүүнээс санал өгснөөс 54 гишүүн дэмжиж, 74.0 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

Гомбожавын Занданшатарыг Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэгт ажлаас чөлөөлөхийг нэгдсэн хуралдаанд оролцон гишүүдийн олонх дэмжсэн тул Гомбожавын Занданшатарыг Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо. /алх цохив/

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. 2026 оны 3 дугаар сарын 27-ны өдөр.

Гомбожавын Занданшатарыг Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай. Улаанбаатар хот.

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 100 дугаар зүйлийн 100.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Гомбожавын Г.Занданшатарыг Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Монгол. Улсын Ерөнхий сайдыг шинээр томилох хүртэл хугацаанд үүрэгт ажлаа гүйцэтгэж байхыг Гомбожавын Занданшарт даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2026 оны 3 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байвал саналаа өгнө үү. Алга байна. /алх цохив/

Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан үндэслэн нэгтгэгдье. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 27 минут үргэлжилж, 21 цаг 55 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД